

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН
2021 ОНЫ 10 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2021.11.04

Сүхбаатар сум

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдийн үйл ажиллагааны талаар:

2020 онд явагдсан орон нутгийн сонгуулийн үр дүнгээр Сэлэнгэ аймгийн нийт 17 сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарын 88.2 хувь нь буюу хоёроос бусад нь шинээр томилогдон ажиллаж байгаатай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанаас сумдын Хурлын дарга нарын сургалтыг зохион байгууллаа. Сургалтаар сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарын зайлшгүй мэдэх шаардлагатай тодорхой салбаруудын хууль тогтоомж, дүрэм, журам, мэдээ мэдээллийг холбогдох газар, хэлтсүүдээр бэлтгүүлэн танилцуулж, цаашид анхаарах асуудлууд болон ойрын хугацаанд анхаарч хэрэгжүүлэх асуудлаар чиглэл өгч санал солилцлоо.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас “Иргэний боловсрол төв” төрийн бус байгууллагатай хамтран аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд сонгогдсон 40 хүртэлх насны залуу төлөөлөгчдийн семинарыг зохион байгууллаа.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ээлжит III хурал хуралдаж салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж, салбар зөвлөлийн гишүүдийн сумдад ажиллах ажлын удирдамж, чиглэл, хуваарийг батлан Мандал, Баянгол сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажлын талаарх салбар зөвлөлийн даргын мэдээлэл, Ерөө, Алтанбулаг сумдын Засаг даргын Тамгын газраас Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээний талаарх сумын Засаг даргын мэдээллийг тус тус сонслоо.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 83 дугаар тогтоолоор “Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл”-ийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн баталсан. Тус журмын хүрээнд аймгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн анхдугаар хуралдаан хуралдаж зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмын талаар танилцуулж зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж зөвлөлийн гишүүдэд гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн цаашид анхаарах асуудлын талаар үүрэг чиглэл өглөө.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 50 дугаар зарлигаар эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан Сэлэнгэ аймгийн харьяат зарим иргэдийг төрийн одон медалиар шагнасан байна. Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 8, Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор 1, Алтан гадас одонгоор 15, Хөдөлмөрийн хүндэт медалийг 12 хүн шагнуулж, шагналыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Б.Нарантуяа, аймгийн Засаг дарга Ш.Оргил нар гардуулан өглөө.

Мөн “Дэлхийн болон Монголын багш нарын өдөр”-ийг тохиолдуулан боловсрол, соёлын салбарт олон жил идэвх зүтгэл үр бүтээлтэй ажилласныг үнэлж Боловсролын

тэргүүний ажилтан цол тэмдгээр 1, аймгийн Хүндэт тэмдгээр 3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хүндэт өргөмжлөлөөр 3 хүнийг шагналаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

2021 оны 3 дугаар улиралд аймгийн хэмжээнд төрийн байгууллага, албан тушаалтанд нийт **3734** иргэн хандаж санал, хүсэлт, өргөдөл, гомдол гаргаснаас **3366** иргэний өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж, **48** өргөдлийг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлж, шийдвэрлэлийн **90.1** хувийн үзүүлэлттэй байна. Төрийн байгууллага, албан тушаалтанд иргэдээс гаргасан санал, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2021 оны 3 дугаар улирлын тайланг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлэн ажилласан.

Төрийн байгууллагын дотоод удирдлагын нэгдсэн систем “ERP.E-Mongolia.mn” цогц системийн сургалтыг аймгийн хэмжээнд цахим хэлбэрээр зохион байгууллалаа. Сургалтад аймгийн 17 сум, 6 тосгоны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, албад, сум, орон нутгийн өмчит газар, Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн нийт 209 байгууллагын 5000 гаруй албан хаагчид 261 нэвтрэх эрхтэйгээр хамрагдлаа.

Австрали Улсын Элчин сайдын яамны Нэгдүгээр нарийн бичгийн дарга тэргүүтэй төлөөлөгчид Сэлэнгэ аймагт албан айлчлал хийж хамтын ажиллагааны талаар санал солилцож мөн Австралийн тэтгэлэгт хөтөлбөрийн албан ёсны танилцуулагыг аймгийн нийт төрийн албан хаагчдад болон хувийн хэвшлийн ажилтан албан хаагчдад сургалт мэдээлэл өглөө.

Хөдөө аж ахуйн менежмент, экосистемийн тогтвортой байдлыг хангах төслийн хүрээнд Европын холбоо, Холбооны Бүгд найрамдах Герман Улсын Элчин сайдын яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нэгдсэн үндэсний байгууллага, Европын сэргээн босголтын банк, “Дэлхийн Зөн” ОУБ-уудын төлөөлөгчид аймгийн удирдлагууд болон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, тухайн төсөл хэрэгжих Мандал, Ерөө, Жавхлант сумдын Засаг дарга нар тэргүүтэй төлөөлөгчидтэй тус төслийн хэрэгжилт цаашдын үр дүн хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцох өндөр дээд хэмжээний албан айлчлалыг зохион байгуулан ажиллаа. Тус уулзалтаар аймгийн газар төлөвлөлтийн ерөнхий төлөвлөгөөг хийх мөн 3 жил хэрэгжих уг төслийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцлоо.

Төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журмын дагуу сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч, соёлын төвийн даргын 17 албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг зохион байгуулж, 10 сул орон тоонд нэр дэвшүүлсэн шийдвэрийг хүргүүлээд байна. Мөн төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын болон дэс, туслах түшмэлийн 110 сул орон тоог нийтэд зарлаж, бүртгэлийг 10 дугаар сарын 25, 26-ны өдрүүдэд хийгээд байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/307 дугаар захирамжийн дагуу “Сэлэнгэ ургац-2021” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, үзэсгэлэн худалдаанд 11 сумын 60 гаруй жижиг дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуй эрхлэгч, ногоочид оролцон, 25.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар 2030 оныг хүртэл өрнүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг аймагтаа өрнүүлж, аймгийн төвийн төр, төсвийн болон орон нутгийн 40 гаруй байгууллагын 400 орчим ажилтан, албан хаагчид “Тужийн

нарсны байгалийн цогцолборт газар”-ын 1 га талбайд 2200 ширхэг 2 наст нарсны тарьцыг суулгалаа.

Мандал суманд 2019 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2.3 тэрбумын өртөгтэй 5.3 км, 2021 оны орон нутгийн төсвийн 300 сая төгрөгийн өртөгтэй 1.1 км бохирын шугам хийгдэж ашиглалтад орлоо. Уг бохирын шугам хийгдсэнээр 15 аж ахуйн нэгж, 170 айлын орон сууц, 200 гаруй айл өрх холбогдох боломж бүрдсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2021оны мн/114 дүгээр тогтоол, Зэвсэгт хүчний Жанжин штабын 2021 оны н/131 дүгээр тушаал, Батлан хамгаалахын сайд Сэлэнгэ аймгийн Засаг даргатай 2021 онд хамтран ажиллах гэрээний 4.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2021 оны “Хугацаат цэргийн албаны ээлжит татлага явуулах тухай” А/272 дугаар захирамжийн дагуу 10 дугаар сарын 06-16-ны өдрүүдэд Мандал, Сайхан, Сүхбаатар сумдад хугацаат цэргийн албаны ээлжит татлагыг бүсчлэн зохион байгуулсан. Үзлэгт хамрагдаж эрүүл мэндийн үзлэгт тэнцсэн татагдагчдыг хугацаат цэргийн албанд тэнцүүлэн татаж Зэвсэгт хүчин, Хил хамгаалах байгууллагад хүлээлгэн өгч хяналтын тоог 100 хувь биелүүлсэн.

Аймгийн Онцгой комиссын үйл ажиллагааны талаар:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Улсын Онцгой комиссын тогтоол, тушаал шийдвэрийн дагуу аймгийн Онцгой комиссын хуралдаанаас гарсан шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангах чиглэлээр сум, агентлаг, аж ахуй, нэгж, байгууллагуудад нийт 48 албан тоотоор үүрэг чиглэл, зөвлөмж, шаардлага, хүсэлтийг хүргүүлж, 25 албан бичгийн бүртгэл хөтлөн хүлээн авч, албан бичгээр ирсэн тайлан мэдээг боловсруулан нэгтгэж, өдөр тутмын нөхцөл байдлын мэдээнд тусгуулах, ирсэн хүсэлтийг холбогдох ажлын хэсэгт хүргэн шийдвэрлүүлэн ажиллаж байна. Шуурхай штабын **70363684, 70360119** дугаарын утсанд **351** мэдээлэл, цахим хаягаар **120** албан бичиг, гар өргөдөл **8** нийт **479** мэдээллийг хүлээн авч шийдвэрлэсэн байна.

Аймгийн Онцгой комисс 3 удаа хуралдан 11 асуудлыг хэлэлцэж 23 асуудлыг шийдвэрлэн аймгийн Засаг даргын захирамж 2, тогтоол 3, хурлын тэмдэглэл 3 гарган албажуулсан. Аймгийн Онцгой комиссын даргаас хийж хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний талаар өгсөн үүрэг чиглэл, мэргэжлийн байгууллагуудаас хэрэгжүүлсэн арга хэмжээ, нөхцөл байдлын мэдээллийг хүлээн авч холбогдох шийдвэрийг гарган, сумдын Онцгой комиссын дарга нарт үүрэг чиглэл хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

“Коронавируст /Ковид-19/-ын халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх талаар аж ахуйн нэгж, байгууллагуудад дагаж мөрдөх журам”-ын хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагуудад халдвар хамгааллын дэглэмийг сахиулж, ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийлгэн журмыг мөрдүүлэн ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудас болон Онцгой байдлын газрын цахим хуудсанд Онцгой байдлын газар, “Дэлхийн Зөн Монгол” ОУ-ын байгууллагатай хамтран “Яагаад амны хаалт зүүх ёстой вэ?”, “Гараа яагаад угаах ёстой вэ?”, “Хамтын хүчээр халдвараас сэргийлье”, “Ковидгүй Сэлэнгийн төлөө” “Жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг оролцуулсан сэрэмжлүүлэг шторк бэлтгэн, 80 удаа мэдээ, мэдээлэл байршуулж 98.000 хандалт авсан.

Мөн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран цаг үеийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг шуурхай бэлтгэн аймгийн Засаг даргын Тамгын газраас “Сэлэнгэ аймаг АЗДТГ”, “Сэлэнгэ Цахим телевиз” цахим хуудас, Зиндаа.мн сайт, Улс төрч.мн сайт, Сүхбаатар сум дахь лед дэлгэц, орон нутгийн “Миний Монгол ТВ”, “Таны Сэлэнгэ ТВ” мөн МҮОНТ-ийн ММ агентлаг, Өлзий

телевиз, Монцамэ агентлаг зэрэг мэдээллийн сувгуудаар мэдээ, мэдээллийг дамжуулан, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Улсын Онцгой комиссын шуурхай штаб, Онцгой байдлын ерөнхий газарт тухай бүр мэдээлэл хүргүүлэн ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын 1 дүгээр давлагаанд **217**, 2 дугаар давлагаанд **15295** нийт **15512** тохиолдолд батлагдаж 2021 оны 10 дугаар сарын байдлаар **13437** иргэн эдгэрч, **37** хүн нас барж, 12 ковидын эмчилгээний тасагт **328** иргэн хэвтэн эмчлүүлж, гэрийн эмчилгээнд **1150** иргэн өрх болон сум, тосгоны Эрүүл мэндийн төвийн хяналтад байна.

Хэвтэн эмчлүүлж байгаа иргэдээс маш хүнд **4**, хүнд **12**, хүндэвтэр **103**, хөнгөн **209** байна. Үүнээс: Жирэмсэн **13**, 0-17 насны **62** хүүхэд байна.

Аймгийн хэмжээнд өссөн дүнгээр нэгдүгээр тун **69549**, хоёрдугаар тун **65195**, гуравдугаар тун **19015** тус тус хийгдээд байна.

10 дугаар сард аймгийн хэмжээнд коронавируст халдвар /ковид-19/-ын **4497** тохиолдол шинээр бүртгэгдэж, **5521** хүн эдгэрч, **7** нас баралт бүртгэгдэж, сүүлийн 2 сарын хугацааг харьцуулж үзвэл батлагдсан тохиолдол 25 хувиар буурсан байна.

Аймгийн хэмжээнд **15512** тохиолдол батлагдсанаас ойрын хавьтал **11846**, дам хавьтал **5707**, нийт **17553** ойрын болон дам хавьтал тогтоогдож байна.

Энэ хугацаанд 23 хяналтын цэгт давхардсан тоогоор 600 Цагдаагийн газрын албан хаагч 23 тээврийн хэрэгсэлтэй, Онцгой байдлын газрын 900 алба хаагч, Эрүүл мэндийн байгууллагын 1470, Мэргэжлийн хяналтын газрын 30 бусад төрийн байгууллагуудтай хамтран нийт 3000 албан хаагч үүрэг гүйцэтгэсэн.

Аймгийн хэмжээнд 1261 цэг байршилд 1172043.6 м² талбайд урьдчилан сэргийлэх болон голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг хийж гүйцэтгэсэн. Шатахуун тээвэрлэлт орох чиглэлд 7, гарах чиглэлд 8, хүнс тээвэрлэлт орох чиглэлд 8, гарах чиглэлд 8, малын өвс тэжээл, үр тариа орох чиглэлд 36, гарах чиглэлд 15 тээврийн хэрэгсэл хөдөлгөөн үйлдсэн байна.

Онцгой байдлын ажил үйлчилгээний талаар:

Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд мал амьтны гоц халдварт “Шүлхий” өвчний дуудлага **1**, объектын гал түймэр **9**, ой, хээрийн түймрийн **3** удаагийн удаагийн дуудлагаар тус тус гарч ажиллалаа. Ой, хээрийн түймэр Баянгол, Ерөө, Хушаат суманд гарч Онцгой байдлын байгууллагын 36 алба хаагч 3 техник хэрэгсэлтэйгээр ажиллаж, түймрийг бүрэн унтрааж сум орон нутагт хүлээлгэн өгсөн.

Монгол Улсын Шадар сайдын баталсан “Төр захиргааны барилга байгууламж”-д Гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, норм, нормативын бичиг баримтын хэрэгжилтийг шалгах төлөвлөгөөт шалгалтын удирдамжийн дагуу төлөвлөгөөт хяналт шалгалтыг Сүхбаатар, Мандал, Баянгол, Сайхан, Баруунбүрэн, Орхон, Сант, Орхонтуул сумдын төрийн захиргааны барилга байгууламжид хийхэд нийт 8 объект хамрагдан 78 зөрчил илэрч, 12 зөрчлийг газар дээр нь арилгуулах арга хэмжээ авч, 66 зөрчил дутагдалд хугацаатай биелүүлэх албан шаардлага, мэдэгдлийг хүргүүлэн ажиллалаа.

Хяналт шалгалтын ажлын мэдээг нэгтгэсэн дүн

Шалгалтанд хамрагдсан объектын тоо	Илрүүлсэн зөрчил	Арилгуулсан зөрчил	Бичсэн							Захиргааны арга хэмжээ							Хэвлэл мэдээлэл
			Албан шаардлага	Мэдэгдэл	Танилцуулга	Дүгнэлт	Акт	АЗ тогтоол	ААНБайгууллага	Төгрөг	Албан тушаалтан	Төгрөг	Иргэн	Төгрөг	Нийт	Төгрөг	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18
8	78	12	4	4	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны Хадлан тэжээл бэлтгэх иргэн, хуулийн этгээд, тээврийн хэрэгсэл, барилга байгууламжид гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт, норм, нормативын хэрэгжилтийг хангуулах удирдамж"-ийн дагуу төлөвлөгөөт хяналт шалгалт Сүхбаатар, Мандал, Баянгол, Сайхан сумуудад хадлан тэжээл бэлтгэж буй иргэд аж ахуйн нэгжийг хамруулан зохион байгуулсан.

Төлөвлөгөөт хяналт шалгалтын мэдээг нэгтгэвэл:

Шалгалтад хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо	Зөрчил		Захиргааны арга хэмжээ							
	Илрүүлсэн зөрчлийн тоо	Шалгалтын явцад арилгуулсан зөрчлийн тоо	Арга хэмжээ авагдсан субъектын тоо	Торгуулийн хэмжээ /төгрөгөөр/	Заавал биелүүлэх албан шаардлагын тоо	Албан мэдэгдлийн тоо	Танилцуулгын тоо	Ажиллагаа зогсоох тогтоолын тоо	Ухуулага сургалт, зааварчилгааны тоо Хүн/цаг	Хэвлэл мэдээллээр сурталчилсан тоо
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
36	39	31	-	-	-	4	-	-	130 хүн	1

Онцгой байдлын газрын даргын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн даргын баталсан удирдамжийн дагуу “Гэр хорооллын айл өрхүүдийн галын аюулгүй байдлыг хангуулах төлөвлөгөөт бус хяналт шалгалт”-ын ажлыг Мандал сум дахь Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах, аврах 19 дүгээр ангийн бие бүрэлдэхүүн Мандал сумын нутаг дэвсгэрт байрлах Төмөр замчдын 1-р баг, Ширхэнцэгийн 2-р баг, Баян суудлын 3-р баг, Хэрх 4-р баг, Баянхангай 6-р баг, Минжийн хангай 7-р баг, Баян-Арцтын 9 дүгээр багийн нийт 26 гудамжинд нийт 240 айл өрхөөр үзлэг шалгалт хийхэд давхардсан тоогоор 12 төрлийн 139 зөрчил дутагдлыг илрүүлж, илэрсэн зөрчлийн 20 хувийг газар дээр нь арилгуулж, барилга байгууламж, объектоос 50 метрээс дотогш зайд хаягдал хог шатаахыг хориглодог, гэр хороололд шатах шингэн, шатах хий ашигласан үйлдвэрлэл явуулахгүй байх талаар анхааруулж, яндангаа хөөлөөгүйгээс яндангийн цонолт үүсч гал түймэр гарах аюултай байдаг талаар болон бусад сэрэмжлүүлгийг 274 иргэнд хүргэж ажилласан.

Мэргэжлийн хяналтын үйл ажиллагааны талаар:

Боловсрол, Соёлын 10, Эм, био бэлдмэлийн хяналтын чиглэлээр 3 эмнэлэг, 5 эмийн сан нийт 8 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлын тодорхой хувийн газар дээр арилгуулж, хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай улсын байцаагчийн албан шаардлагыг хүргүүлэн ажиллалаа. Мөн 1 эмнэлэг, 1 эмийн сан нийт 2 объектын үйл ажиллагаанд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, 18 зөрчил дутагдлыг илрүүлж газар дээр нь 10 хувь буюу 4 зөрчил дутагдлыг арилгуулж, хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай улсын байцаагчийн 14 заалт бүхий 2 зөвлөмжийг хүргүүлэн 8 эрүүл мэндийн төвийн эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдал, коронавирусын эсрэг дархлаажуулалтын явцад хяналт тавин 5 зөрчил дутагдлыг илрүүлэн газар дээр нь арилгуулан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

10 дугаар сарын байдлаар 16 дээжний хариуг хүлээн авлаа. Үүнээс үр тариан 7 дээжний хариу гадны хольц, натур жин, чийг, цэвэршилт, хог ургамлаар тэнцээгүй үзүүлэлт гарч, Жавхлант сумын “НБМНД” ХХК-нд төлөвлөгөөт хяналт шалгалт хийн, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн 18-02-039/187 дугаар 10 заалт бүхий албан шаардлагыг хугацаатай өгч ажиллаж, Жавхлант, Цагааннуур, Зүүнбүрэн, Хушаат, Сайхан сумдын хохирол тооцох ажлын хэсгийн 8600 га талбайд актад тулгалт хийж, илэрсэн зөрчлийг газар дээр нь арилгуулан ажиллалаа.

Байгаль орчны хяналтын чиглэлээр Мандал Баянгол, Бугант, Ерөө сумдад уул уурхайн хяналтын чиглэлээр хамтарсан хяналт шалгалтыг хийж нийт 3.500.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ тооцож, Геологи, уул уурхайн хяналтын чиглэлээр Мандал Баянгол, Ерөө сумдад ажиллаж нийт 6 аж ахуйн нэгж байгууллагыг хамруулан илэрсэн зөрчилд 40.000.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан.

Стандартчилал, хэмжил зүйн үйл ажиллагааны талаар:

Үйлчилгээний баталгаажуулалт: Баянгол, Сүхбаатар, Жавхлант, Хушаат, Орхонтуул, Баруунбүрэн, Сант, Орхон, Сайхан, Хөтөл, Шаамар, Түшиг, Цагааннуур сумын 35 аж ахуйн нэгжийн 41 үйлчилгээний газарт тохирлын үнэлгээ хийж, Монгол Улсын “Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 5021-1:2019”, “Хоолны газрын үйлчилгээ, Ерөнхий шаардлага MNS 4946:2019”, “Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ, Дэн буудалд тавих шаардлага MNS 5738:2007”, “Амралтын газар, жуулчны баазад тавих ерөнхий шаардлага MNS 6043:2019” стандартын шаардлага хангасан 35 иргэн, аж ахуйн нэгжийн 41 үйлчилгээний газарт, “Рапсын түүхий тос. Техникийн шаардлага MNS 1536:2015”, “Рапсын шахдас, Техникийн шаардлага MNSGB22514:2015” стандартын шаардлага хангасан 1 аж ахуй нэгжийн, 1 бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ олгосон.

Стандарт, мэдээллийн салбар сангаас 6 аж ахуй нэгж, байгууллага иргэний захиалгын дагуу 15 нэрийн 18 стандарт борлуулж, мэдээлэл арга зүйн зөвлөмж өгч, албан хэрэгцээнд 3 нэрийн 3 стандарт олгосон.

Эзлэхүүн хэмжлийн төрлөөр: 14 сумдын 28 шатахуун түгээх станцын 86 түгээгүүр, 1 АХЦС-ын нийт 60 хэмжих хэрэгсэл 4 аж ахуй нэгжийн 5 усны тоолуурт ээлжит баталгаажуулалт шалгалт тохируулга хийсэн.

Механикийн хэмжлийн төрлөөр: 108 электрон жин, 3 авто пүү, 2 термометрийг баталгаажуулах ажил хийсэн.

Дулаан даралтын хэмжлийн төрлөөр: 2 цусны даралтын аппарат шалган баталгаажуулсан.

Цахилгаан хэмжлийн төрлөөр: Айл өрх, аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж буй 1 болон 3 фазын 19 тоолуурыг шалган баталгаажуулсан.

Шалгалт тохируулга: Сүхбаатар сумын “Сэлэнгэ ус” ОНӨААТҮГ-ын сорилтын лабораторийн 2 электрон жинд шалгалт тохируулга хийж ажиллалаа.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

Тус сард 735 баримтаар 10'116'577.4 мянган төгрөгийн төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог хянан гүйцэтгэлээ.

Аймгийн 09 сарын төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн мэдээг гаргаж Статистикийн хэлтэст хугацаанд нь хүргүүлж, мөн сарын аймгийн орлогын гүйцэтгэлийн мэдээг татварын хэлтэстэй тулган баталгаажуулж, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр аймгийн web сайт, шилэн данс болон ил тод самбарт байршуулан ажиллаж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг сум бүрд хуваарилан тавьж, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт олгосон.

2022 оны төсвийн төслийг Сангийн ямаар батлуулахаар хуваарийн дагуу сумд болон байгууллагуудын төслийг хянуулж ажиллалаа.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1. Орон нутгийн төсвийн нийт орлого		83,137,203.5	85,208,662.0	102.5
1.1	Орон нутгийн төсвийн орлого	18,819,078.0	24,540,788.0	130.4
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	13,181,743.3	15,048,913.6	114.2
	Сумдын төсвийн орлого	5,637,334.7	9,491,874.4	168.4
1.2	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	3,717,621.3	3,717,621.3	100.0
1.3	Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг	41,327,749.5	41,327,749.5	100.0
1.4	Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох шилжүүлэг	492,267.6	459,939.4	93.4
1.5	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг	5,924,484.3	6,843,709.4	115.5
1.6	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/	6,641,696.7	6,641,696.7	100.0
1.7	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	2,299,871.5	114,502.4	5.0
1.8	Төсөвт байгууллагын өөрийн орлого	294,980.1	329,017.2	111.5
1.9	ОНХС-д хандив	1,430,000.0		
1.10	Сум хөгжүүлэх сан /орлого/	2,189,454.5	1,233,638.0	56.3
2. Орон нутгийн төсвийн нийт зарлага		83,137,203.5	65,872,642.6	79.2
2.1	83,137,203.5	83,137,203.5	65,872,642.6	79.2
	Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага	20,121,306.1	14,828,955.5	73.7
	Сумдын орон нутгийн хөгжлийн сан	4,040,368.3	1,705,498.9	42.2
	Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага	12,228,618.1	8,048,002.8	65.8
	Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт	781,695.0	173,811.7	22.2
	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	4,589,285.6	2,306,746.9	50.3

	Халамжийн сан	124,939.4	54,435.5	43.6
	Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага	5,532,462.8	4,584,476.8	82.9
	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	1,200,235.3	928,531.9	77.4
	Сумдын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	46,006,903.8	40,609,786.9	88.3
	Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	740,007.2	680,398.5	91.9
3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг		57,959,060.7	58,878,285.8	101.6
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	10,706,826.9	10,706,826.9	100.0
3.2	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	2,817,241.9	2,817,241.9	100.0
	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	106,006.5	106,006.5	100.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд			
	Хөрөнгө оруулалтын зардалд	2,711,235.4	2,711,235.4	100.0
3.3	Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	3,107,242.4	4,026,467.5	129.6
	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	2,766,091.8	3,685,316.9	133.2
	Усны татаас	319,500.0	319,500.0	100.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд	21,650.6	21,650.6	100.0
3.4	Сумдад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	40,630,406.6	40,630,406.6	100.0
3.5	Аймагт олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	697,342.9	697,342.9	100.0
3.6	Тусгай зориулалтын шилжүүлэг /салбараар/	41,327,749.5	41,327,749.5	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	22,193,585.7	22,193,585.7	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	11,330,816.2	11,330,816.2	100.0
	- Эрүүл мэндийн байгууллага	6,996,639.6	6,996,639.6	100.0
	- Газрын кадастрын байгууллага	422,810.2	422,810.2	100.0
	- Хүүхдийн байгууллага	407,619.8	407,619.8	100.0
4. Тусгай сангуудын зарлага		2,189,454.5	1,233,638.0	56.3
4.1	Сумдын сум хөгжүүлэх сан	2,189,454.5	1,233,638.0	56.3

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2020 09- сар	2021 09- сар	2021-09 2020-09 Х/төгрөгөөр/
1.ХҮНСНИЙ БАРАА				
1	ТАЛХ, ГУРИЛ, БУДАА			
	Гурил /савласан, кг/	1 200	1 650	137.5
	Талх /орон нутгийн, ш/	1 300	1 400	107.7
	Нарийн боов /кг/	2 600	4 000	153.8
	Будаа /кг/	2 600	2 700	103.8
	Элсэн чихэр /кг/	2 000	2 400	120.0

2	МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
	Хонины мах /кг/	7 500	8800	113.3
	Үхрийн мах /кг/	8 000	9 800	122.5
	Адууны мах /кг/	6500	7500	115.4
	Ямааны мах /кг/	6500	7 500	115.4
	Дотор мах, цувдай /цусгүй/	5 000	5 000	100.0
	Хиам /чанасан, кг/	11 000	12 500	113.6
3	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	900	1 200	133.3
	Сүү / савласан, л/	3 200	3200	100.0
	Тараг /задгай, л/	1 100	1 300	118.2
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	16 000	21 000	131.3
	Айраг /л/	4 000	5 000	125.0
	Хуурай сүү /кг, Орос, 25 хувь тослогтой/	4 500	4 500	100.0
	Өндөг /ш/	350	350	100.0
4	БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС			
	Ургамлын тос /л/	4 500	5 300	117.8
	Өөхөн тос /кг/	2 500	2800	112.0
	Шар тос /кг/	15 000	20 000	133.3
	Масло /задгай, кг/	4 500	4 700	104.4
5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	1 000	1 500	150.0
	Лууван /кг/	1 100	2 400	218.2
	Манжин /кг/	1 500	2 100	140.0
	Байцаа /кг/	1200	1 200	100.0
	Сонгино /кг/	1 500	2 500	166.7
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3 500	5 500	157.1
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2 800	4 700	167.9
7	ШАТАХУУН			
	Бензин А - 80	1 420	2040	143.7
	Бензин А - 92	1470	2070	140.8
	Дизелийн түлш	2 090	2490	119.1

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Аймгийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн “Хөтөлбөр хэрэгжүүлэх, аян зохион байгуулах тухай” А/292 дугаар захирамжаар шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх, төрийн үйлчилгээний ил тод байдлыг нэмэгдүүлэх, хяналт хариуцлагыг дээшлүүлэх, удирдах ажилтны авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэлийг нэмэгдүүлэх, захирах захирагдах ёсны зарчмыг хэрэгжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцөлийг арилгуулах, ажлын үр дүнг дээшлүүлэх зорилгоор “Шударга Удирдагч, Шударга Төрийн албан хаагч” аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулах ажлыг эхлүүлээд байна.

Авлигатай тэмцэх газраас 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдөр ирүүлсэн “Авлигатай тэмцэх газрын ажлын хэсгийн орон нутагт ажиллах удирдамж”-ийн дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн авлигатай тэмцэх газрын орон нутагт ажиллах удирдамжийн төлөвлөгөөг батлуулж, холбогдох нэгжүүдээс мэдээллийг гарган хянуулах ажлыг зохион байгуулсан. Тус удирдамжийн дагуу аймгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын удирдлагууд болон телевиз, радио, сонины редакц, сайт, хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтнууд, “Зөв зөвд

шударга зөв” соён гэгээрүүлэх аяны хүрээнд орон нутагт ажил зохион байгуулсан, хамтран оролцсон байгууллагуудын удирдлагуудтай тус тус цахимаар уулзалт зохион байгуулсан.

Цагдаагийн газар: Аймгийн хэмжээнд 2021 оны 10 дугаар сард 396 холбогдогчтой 1985.4 сая төгрөгийн хохиролтой 535 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 20 хэргээр буюу 3.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн илрүүлэлт 50.1 хувьтай байгаа нь өмнө оныхоос 0.6 хувиар өссөн байна.

Улсын бүртгэлийн хэлтэс:

- Төрсний бүртгэл - 162 /эрэгтэй-76, эмэгтэй-86/
- Гэрлэлтийн бүртгэл - 19
- Гэрлэлт цуцалсны бүртгэл - 10
- Үрчлэлт - 5
- Эцэг тогтоолт - 11
- Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл - 9
- Нас баралт - 95
- Нийт олгосон иргэний үнэмлэх - 389
- Шинээр олгосон иргэний үнэмлэх - 218
- Дахин олгосон иргэний үнэмлэх - 137
- Иргэний үнэмлэхийн хугацаа дуусч солиулсан - 190
- Гадаад паспорт олголт - 26
- Аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн - 71



Төрийн архивт хийгдэх бүрдүүлэлтийн 2021 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу байгууллагын архивт хадгалах хугацаа дууссан байнга хадгалах баримтыг шилжүүлэн авах ажлыг явуулсан бөгөөд өнгөрсөн долоо хоногт аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2005-2013 оны 34 ХН, Нийгмийн даатгалын хэлтсийн 2001-2013 оны 28 ХН, захирамжлалын баримт бичгүүдийн цахим хувиудыг холбогдох бүртгэл, жагсаалтын хамт шилжүүлэн авлаа.

Төрийн архивын дэргэдэх Баримт нягтлан шалгах арга зүйн комиссын 2021 оны ажлын төлөвлөгөөний дагуу ээлжит хурлыг хийж, хөмрөг үүсгэгч байгууллагуудаас ирүүлсэн байнга хадгалах баримтын бүртгэлд 3412, түр хадгалах баримтын бүртгэлд 569, устгах хэргийн актад 2190 хадгаламжийн нэгжийг хэлэлцэн баталсан бөгөөд засвар өөрчлөлт хийх шаардлагатай бүртгэл, актуудыг буцаан хүргүүлэхээр бэлтгээд байна.

Иргэд, албан байгууллага болон цахимаар ирүүлсэн хүсэлтийн дагуу 10 дугаар сард нийт 90 гаруй иргэнд үйлчилж 155 архивын хуулбар, 26 архивын магадлагаа тодорхойлолт гаргаж үйлчилсэн байна.

Дөрөв. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

Боловсрол, соёл урлаг, спортын талаар: Ерөнхий боловсролын 11 сургууль танхимаар, 19 сургууль 5/9-ийн зарчмаар танхим, цахим хосолсон хэлбэрээр, 5 сургууль цахимаар, цэцэрлэгүүдээс 2 цэцэрлэг цахимаар хичээллэж, коронавирусын халдвараар өвдсөн багш, сурагч, удирдах ажилтан, бусад ажилтны мэдээллийг өдөр бүр авч, нэгтгэн ажиллаж байна.



Бага боловсролын суралцагчдын сурлагын хоцрогдлыг бууруулах, арилгахад дэмжлэг үзүүлэх зорилготой Боловсролын чанарын шинэчлэл төслийн “Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр”-ийн 5 дахь шатны төслийг хэрэгжүүлэхээр сонгогдсон 26 сургууль, Боловсролын газрын төслийн 194,0 сая төгрөгийн санхүүжилтийг хүлээн авч шилжүүлэн, төсөл хэрэгжүүлэхэд анхаарах асуудлын талаар төслийн албатай хамтран сургалт явууллаа.

Монгол Улсад боловсролын салбар үүсч хөгжсөний 100 жил, Дэлхийн тогооч нарын өдрийг тохиолдуулан сургууль, цэцэрлэгт ажиллаж буй тогооч нарыг шагнаж урамшуулах арга хэмжээг зохион байгуулж “Хөдөө аж ахуй, үйлдвэр, худалдаа, үйлчилгээний салбарын тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр 8, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны “Жуух бичиг”-ээр 8 тогоочийг шагналаа.

2021-2022 оны хичээлийн жилд “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль”-ийн хэрэгжилтийг ханган үдийн цайг үдийн хоол болгон 1500 төгрөгөөр тооцож, нийлүүлэх болсонтой холбоотой хоол үйлдвэрлэлийн нөхцөл байдлын судалгаа ба хоол үйлдвэрлэх явц, зохион байгуулалт, түүнд гарч буй тулгамдсан асуудлын талаар мэдээлэл цуглуулан тайлан, зөвлөмж бичиж БШУЯ болон сургуулиудад хүргэн ажилласан.

Коронавируст халдвар /Ковид-19/-аар өвдсөн болоод эдгэрсэн хүүхдүүд ичиж байгаа ялгаварлан гадуурхагдахаас айж сэтгэл зүйн хувьд дарамттай байгаа тухай эцэг эхчүүдээс удаа дараа БШУЯ-нд гомдол, санал ирүүлсэнтэй холбоотой сургуулийн нийгмийн ажилтнуудтай цахим уулзалтыг зохион байгуулж, уулзалтаар ковидын талаар, ханиадны нэг төрөл болох, айж, ичих зүйл биш гэдэг талаас нь суралцагчдын нас сэтгэхүйн онцлогт тохируулан анги удирдсан багш, эмчтэй хамтран богино хугацааны мэдээлэл, сургалтаар дамжуулан суралцагчдын нийгэм, сэтгэл зүйн эерэг ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх, цаашид үүсэж болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлж ажиллах чиглэл, зөвлөмжийг өглөө.

Гадаад хамтын ажиллагааны хүрээнд БНСУ-ын Жэжү аймгийн Засаг захиргаа, Боловсролын газраас хэрэгжүүлж буй 4 дэх удаагийн төслөөр Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1-р сургуульд 36 хүүхдийн суудалтай нийт 170,0 сая төгрөгийн өртөг бүхий Мэдээллийн технологийн сургалтын иж бүрэн кабинетын дэмжлэг үзүүлж угсралтын ажлыг MS Korea компани гүйцэтгэж, хүлээлгэн өглөө.

БШУЯ-наас зохион байгуулсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй бага ангийн багш нарт зориулсан Дохионы хэлний анхан шатны сургалтад аймгийн 24 багш хамрагдлаа.

Монгол-Оросын найрамдлын сарын хүрээнд “Орос хэл, соёлын бүсийн арга хэмжээ” Төв аймагт зохион байгуулагдаж, лаборатори 4 дүгээр сургуулийн орос хэлний багш Д. Мөнх-Учрал, Сүхбаатар сумын 2 дугаар сургуулийн орос, англи хэлний багш С.

Алтангадас, Сүхбаатар сумын 2 дугаар сургуулийн 12-р ангийн сурагч Ж. Дөлгөөн нар аймгаа төлөөлөн оролцлоо.

2021 оны 10 дугаар сард ерөнхий боловсролын сургуулиас тэтгэвэрт гарсан 4 багш, ажилтанд 58.363.584 төгрөгийн, сургуулийн өмнөх боловсролын байгууллагаас тэтгэвэрт гарсан 4 багш, ажилтанд 35.776.135 төгрөгийн, Хөдөө орон нутгийн дэмжлэгт ерөнхий боловсролын сургуулиас 11 багшид 50.021.358 төгрөг, сургуулийн өмнөх боловсролын байгууллагаас 6 багш эрхлэгчид 26.853.714 төгрөгийн тэтгэмжийг олгосон байна.

Иргэд аж ахуй нэгж, байгууллагуудын албан хаагчдыг дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллүүлэх түүгээр дамжуулан биеийн дархлааг дэмжих зорилгоор “Ажлын байрандаа дасгал хийж дархлаагаа дэмжье” аяныг 2021 оны 09 дүгээр сарын 15-аас 10 дугаар сарын 20 хүртэл зохион байгуулагдлаа. Аянд нийт 12 байгууллагын 86 төрийн албан хаагчид оролцсоноос Сэлэнгэ аймгийн хэмжээнд:

- 1 байр - Алтанбулаг сумын Найрамдал цэцэрлэг
- 2 байр - Баянгол сумын 1дүгээр цэцэрлэг
- 3 байр - Цагааннуур сумын 1дүгээр цэцэрлэг
- Тусгай байр - Мандал сумын 3 дугаар сургуулийн хамт олон
- Гаалийн газрын хамт олон шалгарлаа.

Шаамар-Алтанбулаг-Сүхбаатар-Улаанбаатар чиглэлийн 400 км буухиа гүйлт Ардын хувьсгалын 100 жил, Биеийн тамир, спортын 100 жил, Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 90 жилийн ойд зориулсан Шаамар-Алтанбулаг-Сүхбаатар-Улаанбаатар чиглэлийн 400 км буухиа гүйлтийн нээлт зохион байгуулагдлаа.

(Vitality Running World Cup-2021 зохиогдох болсонтой холбоотойгоор MGL Running Channel-аас Run World Cup апп дээр teammonoliarunasonenation-Team Mongolia-Run as One Nation багтаа бүртгүүлэн Монгол улсынхаа нэрийг гаргахаар зорин гүйж байгаа 1,2,3 шатанд Сэлэнгэ аймгаа төлөөлж 32 гүйгч гүйснээс Сэлэнгэ аймгийн Биеийн тамир спортын газрын Хөнгөн атлетикийн дасгалжуулагч багш Г.Гантөмөр хамгийн хол км гүйж TOP-20 шалгарч Team Mongolia 1-р байр, TEAM MONGOLIA-Run As One Nation 2-р байр эзэлж, Цахим гүйлтийн ДАШТ-д Монгол улс ноднин 173 улсаас 18-р байранд орж байсан бол энэ жил 146 улс оролцсоноос 3-р байр эзэлж эх орондоо болон гадаадад суугаа гүйгчид маань хамтдаа 51000 гаруй км гүйсэн байна.

Багахангай дүүрэгт Монголын Хэт Холын Марафон гүйлтийн холбооны нэрэмжит “Багахангай марафон-2021” улсын аварга шалгаруулах тэмцээнд Сэлэнгэ аймгийн багт тамирчид амжилттай оролцож 5*10 км буухиа гүйлтэд 5 дугаар байр, 50 км кросс гүйлтэд Л.Сүхбаатар, Ж.Батсуурь нар шагналт байранд орсон амжилт үзүүллээ.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, нийгмийн даатгалын хүрээнд: Халамжийн санд улсын төсвөөс тайлант хугацаанд 34648 иргэнд 14752975.9 мянган төгрөгийг олгоод байна. Үүнд:

1. Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2350 иргэнд 6612057.9 мянган төгрөг
2. Нийгмийн халамжийн тэтгэмжид 1835 иргэнд 1439129.5 мянган төгрөг
3. Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмжид 1741 иргэнд 993983.8 мянган төгрөг
4. Жирэмсэн эхийн тэтгэмжид 1086 эхэд 289335.1 мянган төгрөг
5. 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж 5079 эхэд 2373663.8 мянган төгрөг
6. Ихэр хүүхдийн тэтгэмжид 18 иргэнд 36000.0 мянган төгрөг
7. Эхийн алдар одонгийн тэтгэмжид 8851 иргэнд 1174400.0 мянган төгрөг
8. Насны хишиг тэтгэмжид 5121 иргэнд 805000.0 мянган төгрөг

9. Өрх толгойлсоны тэтгэмж 256 иргэнд 296276.9 мянган төгрөг
10. Ахмадын настанд олгох хөнгөлөлт, тусламжид 2287 ахмадын 148577.9 мянган төгрөг
11. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх хөнгөлөлт, тусламжид 597 иргэний 120478.8 мянган төгрөг
12. Хүнсний эрхийн бичгийн 5427 иргэнд 464071.9 мянган төгрөгийг тус тус зарцууллаа.

Орон нутгийн төсвийн орлогоос: Халамжийн санд орон нутгийн төсвөөс тайлант хугацаанд орон гэрийн хөнгөлөлт, тусламжид 26 иргэнд 31200.0, ОНОТХҮ төсөлд 28 иргэнд 22400.0 мянган төгрөгийг нийт 54 иргэнд 53600.0 мянган төгрөгийг олгоод байна.

2021 оны 09-р сарын 25-ны байдлаар бүртгэлтэй ажил хайгч 697 байсан бол 314 иргэн шинээр бүртгүүлж, ажил олгогчоос ирүүлсэн 283 ажлын байранд 224 хүнийг ажилд зуучилж, идэвхгүйн улмаас 106 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 681 болсон байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны төсвийн шинэчилсэн хуваарь 656674.2 мянган төгрөг, Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр 15315.0 мянган төгрөгөөр батлагдаж ирсэн.

2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аймгийн Төрийн Аудитын газар “ЗӨРЧИЛГҮЙ” санал дүгнэлт өгсөн.

Орлого: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 626126.0 мянган төгрөгийн санхүүжилт 99.9 хувь, Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр 15315.0 санхүүжилт 100 хувь орж ирсэн. Мөн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт 289 иргэний 377668.1 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөр 5 байгууллагын 35172.0 мянган төгрөг орж ирсэн байна.

Зарлага:

1. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээнд 445хүнд 2034.4 мянган төгрөг,
 2. Ажилд зуучлах үйлчилгээнд 731 хүнд 1707.1 мянган төгрөг,
 3. Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрт 125 хүнд 6078.6 мянган төгрөг,
 4. Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрт 240 хүнд 268852.5 мянган төгрөг,
 5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 73 хүнд 104758.0 мянган төгрөг,
 6. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 10 хүнд 27840.0 мянган төгрөг,
 7. Жижиг зээлийн хүүгийн хөнгөлөлтөд 1 хүнд 700.0 мянган төгрөг,
 8. Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн сүлжээг бүрдүүлэх, ажиллуулах, шинэчлэх 280.0 мянган төгрөг
 9. Сурталчилгаа, олон нийтийн арга хэмжээ, хөдөлмөрийн яармаг, өдөрлөг зохион байгуулах, хууль тогтоомж, эрх зүйн актын уулзалт, хэлэлцүүлэгт 640.0 мянган төгрөг,
 10. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хяналт, шинжилгээ, үнэлгээ хийхэд 1305.5 мянган төгрөг
 11. Гарын авлага, хэвлэмэл материал бэлтгэх, хэвлүүлэхэд 667.7 мянган төгрөг
- Нийт 414863.8 мянган төгрөг зарцуулан ажилласан байна. Зарцуулалт 66.3 хувьтай байна.

Эргэн төлөлт төвлөрүүлэлт: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв санд санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт болох 324765.6 мянган төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөр 34020.0 мянган төгрөг нийт 358785.6 мянган төгрөг төвлөрүүлэн ажиллаж байна.

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар: Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагын чадавхийг бэхжүүлэх, хүүхдийн амьдралын бүхий л талбарт хүүхдийн оролцоог тодорхойлох, хүүхдийн төлөө хийж байгаа ажлуудыг хүүхдийн нүдээр харж үнэлэх, тэдэнд тулгамдсан асуудлыг бодлого шийдвэрт тусгах зорилгоор “ОРОЛЦООД ХӨГЖЬЕ” үндэсний цахим чуулган зохион байгуулагдлаа. Чуулганд аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл, Эрүүл мэндийн газар, Боловсролын газар, Цагдаагийн газар, Орхонтуул, Сайхан сумын хүүхдийн оролцооны байгууллагын төлөөлөл, Мандал сумын “Хүслийн хөтөч” Хүүхэд хамгаалал, оролцооны клубийн гишүүд, төрийн бус байгууллага, нийт 38 төлөөлөл оролцсон. Оролцогч хүүхдүүдээс сургууль бүр эмч, сэтгэл зүйч, гоо зүйч, хүүхдийн байгууллагын харьяа зуслан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ялгаварлан гадуурхалт, хүүхдийн ордонтой болох зэрэг тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэхээр Хүүхдийн төлөө зөвлөлд өргөн барилаа.

“Дэлхийн Охидын эрхийг хамгаалах Олон улсын өдөр”-ийг тохиолдуулан охидод тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх, тэдний эрхийг хамгаалах зорилгоор “ЭЭЖ ОХИН” цахим өдөрлөг зохион байгууллаа. Тус өдрийн хүрээнд холбогдох байгууллагуудтай хамтран “Өөртөө итгэх итгэл”, “Охидын бэлгийн ариун цэвэр, эрүүл ахуй”, “Миний бие миний аюулгүйн дүрэм” сэдвээр 80 гаруй охид, ээжүүдэд зөвлөгөө мэдээллийг өгч, Сэлэнгэ хүүхэд, Сэлэнгэ залуучуудын хөгжлийн төв, Зүүнхараа хүүхдийн ордон фейсбүүк цахим хуудсаар шууд дамжууллаа.

“Гэр бүлийг дэмжих туршилтын хөтөлбөрийн гэрээр айлчлагч нарын ажлыг дүгнэх, урамшуулах” ажлын хүрээнд 10 гэрээр айлчлагчийг шалгаруулж, өргөмжлөл гардууллаа.

Канад Улсын Засгийн газрын дэмжлэгтэй Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагын Монгол Улсад Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлэх төслийн хүрээнд “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид эрх зүйн туслалцаа үзүүлэх нь” танхимын сургалтад хамрагдсан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны даргын 2021 оны А/20 дугаар тушаалаар “Нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны үйл ажиллагаанд хяналт, дүн шинжилгээ хийх” ажлын хэсгийн бүрэлдэхүүн Мандал, Алтанбулаг сумдын Түр хамгаалах байрны үйл ажиллагаанд хяналт, дүн шинжилгээ хийлээ.

Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангахад төр, хувийн хэвшил, иргэний оролцоог нэмэгдүүлэх, гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, мэдээлэх, олон нийт, эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Хэрсүү гурвалжин” нөлөөллийн арга хэмжээ зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд “Хэрсүү гурвалжин”, “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” шторк контентийг долоо хоногийн давтамжтай Сэлэнгэ хүүхэд пэйж хуудас, аймгийн зарын группүүдэд байршуулж, Цагдаагийн газартай хамтран “Хэрсүү ус түгээгч”, “Соргог хөрш”, “Хариуцлагатай худалдагч” арга хэмжээг зохион байгуулж, дэлгүүрийн худалдагч, хөрш айл, худгийн ус түгээгч нарт яриа таниулга хийн, постер мэдээлэл хүргэлээ.

Залуучуудын хөгжлийн төвөөс “Хорт зуршлаас хайртай бүхнээ хамгаалъя” уриан дор “ХОРТ ЗУРШИЛГҮЙ ЗАЛУУ” аяныг өрнүүллээ. Тус аянаар өсвөр үе, залуучуудад архи, тамхины хор хөнөөлийг сурталчлах, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж, нийт 35 аж ахуйн нэгж, хүнсний дэлгүүрүүдэд уриалга, зөвлөмж гарын авлага тараан байршууллаа.

Сүм хийдэд шавилан суралцаж байгаа хүүхдэд тулгамдсан асуудлыг тодорхойлох, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 6 сумын 20 сүм, хийдэд төлөвлөгөөт хяналтыг зохион байгуулж, сүм хийдэд суралцаж буй хүүхдийг бүртгэлжүүлэх, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах талаар шаардлага тавьж, зөвлөгөө өглөө. Ковид-19 цар тахалтай холбоотойгоор 13 сүм үйл ажиллагаагаа түр зогсоосон байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь явуулын хурлыг Баянгол, Мандал, Түнхэл, Сайхан, Сант, Орхон, Орхонтуул, Рашаант, Хушаат, Номгон зэрэг сум тосгодын хүүхдийг хамруулан зохион байгуулж, нийт 34 хүүхдийн асуудлыг шийдвэрлээ.

Баянгол, Ерөө сумдууд Залуучуудын чуулга уулзалтаа цахимаар болон танхимаар зохион байгууллаа. Нийт 117 залуучууд оролцож санал бодлоо солилцон, гаргасан санал санаачилгуудаа сум орон нутгийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгахаар боллоо.

Тав. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хүрээнд:

Мал эмнэлгийн үйлчилгээний талаар: Засгийн газрын 225-р тогтоолын 1,2,3-р хавсралтаар батлагдсан төлөвлөгөөний дагуу аймгийн Засаг даргын 2021 оны “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах тухай” А/101, “Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай” А/236 тоот захирамжаар технологит хугацаанд давхардсан тоогоор 12 нэр төрлийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд энэ онд нийт 1.241.400 толгой мал, амьтан хамруулахаас **1-р хавсралтад** заасан өвчин 1.021.600 толгой мал амьтан хамруулахаас 1041536 толгой мал, амьтан буюу 101.9 хувь **2-р хавсралтад** заасан өвчин 219.000 толгой мал, амьтан хамруулахаас 238680 тол мал, амьтан буюу 108.9 хувь, **3-р хавсралтад** заасан өвчин 432.000 толгой мал амьтан хамруулахаас 461.000 толгой мал буюу 106.7 хувь буюу нийт **1.672.600** толгой мал, амьтан хамруулахаас **1.741.216** толгой мал, амьтныг хамруулсан.

Мандал суманд гоц халдварт шүлхий өвчин оношлогдож тус сумын мал, амьтныг уг өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний вакцинжуулалтад 119.531 толгой мал, амьтан хамруулахаас 119896 толгой мал, амьтныг хамруулан ажилласан.

Аймгийн хэмжээнд 285.360 толгой малыг сүргийн эрүүл мэндийн үзлэгт хамрууллаа.

Хүнсэнд: 933 гэрчилгээгээр адуу 127, үхэр 1081, хонь 3918, ямаа 1175, гахай 16 толгой буюу нийт 6317 толгой мал, амьтан, 46350 кг мах, махан бүтээгдэхүүн, 4710 кг сүү, сүүн бүтээгдэхүүн, 247 ширхэг арьс шир, түүхий эд буюу нийт 51354 кг, ширхэг бүтээгдэхүүнд мал эмнэлгийн гэрчилгээ олгож, цахим мэдээллийн сан үүссэн мэдээтэй байна.

Шилжилт хөдөлгөөн: 30 гэрчилгээгээр адуу 23, үхэр 45, хонь 73, ямаа 55 толгой буюу нийт 196 толгой мал, амьтан шилжилт хөдөлгөөн хийсэн байна. Үүнд өөр аймаг, сумдаас ирсэн нийт 47 толгой /отор 5, үржилд 42/, өөр аймаг сумд руу явсан нийт 35 толгой /отор 16, үржилд 19/, аймаг дотроо нийт 114 толгой /отор 5, үржилд 109/ мал, амьтан тус тус хийгдсэн байна.

Хүдэр, Орхонтуул, Шаамар, Сүхбаатар, Алтанбулаг, Баруунбүрэн, Баянгол, Ерөө, Жавхлант, Зүүнбүрэн, Мандал, Цагааннуур сумдад нийт 64 удаагийн мал, амьтны халдваргүй өвчний дуудлага мэдээлэл ирснийг цаг алдалгүй үйлчилгээ үзүүлж, эмчилгээ хийж, мэргэжил арга зүйн заавар зөвлөгөөг малчид, мал бүхий иргэд өгч ажиллалаа.

Сүхбаатар сумын хэмжээнд хүнсний зах, дэлгүүрт худалдан борлуулж байгаа мах, махан бүтээгдэхүүний 9606 кг үхрийн махны 85 дээж, 2637 кг хонины махны 183 дээж, 1459 кг ямааны 112 дээж, сүү, сүүн бүтээгдэхүүний 430 л сүүний 5 дээж, 110 л тарагны 2 дээжид ариун цэврийн магадлан шинжилгээг хийж гүйцэтгэсэн.

Цагааннуур, Зүүнбүрэн, Түшиг, Баянгол, Мандал, Баруунбүрэн, Жавхлант сумдын 253 бух, 2515 үнээ, 158 хуц, 123 ухна, нийт 3049 дээжид ийлдэс судлалын шинжилгээг хийж халдварлалтгүй болохыг тогтоож хариуг баталгаажуулан малчин, мал бүхий иргэнд, хүргүүлж цахим системд бүртгэсэн. Хонь, үхэр, адууны 45 баасны дээжид цагаан хорхойн өндөг илрүүлж тоолох шинжилгээг хийж гүйцэтгэсэн.

Хөдөө аж ахуйн талаар: Аймгийн хэмжээнд хаврын тариалалтад үр тарианы 304 аж ахуй нэгж, 199 иргэн, төмс, хүнсний ногооны 33 аж ахуйн нэгж, 2251 иргэн 209 мянган га талбайд тариалалт хийсэн.

2021 оны хаврын тариалалтын эцсийн байдлаар 148.3 мян.га талбайд үр тариа тариалснаас улаанбуудай 138.5 мян.га буюу 88.1 хувьтай, 4599 га-д арвай, 4866 га-д овьёос, 300 га гурвалжин будаа, тэжээлийн ургамал 12979 га буюу 149 хувьтай, тосны ургамал 47.9 мян.га буюу 225 хувьтай, төмс 2581 га буюу 94 хувьтай, хүнсний ногоо 2936 га буюу 107 хувьтай тариалалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

2021 оны 10 дугаар сарын байдлаар 34 мян.га талбайг ангилан хадаж, 108,7 мян.га-аас 13.8 цн буюу 150.4 мянган тонн улаанбуудай 80.6 хувьтай, 2.1 мян.га-аас 23 мян.тн төмс 98.8 хувьтай, 2.5 мян.га-аас 32 мян.тн хүнсний ногоо 96.8 хувьтай, 4,5 мян.га-аас 7 мян.тн тэжээлийн ургамал 33 хувьтай, 25.6 мян.га-аас 14.2 мян.тн тосны ургамал 53 хувьтай тус тус хураан авч нийт үр тариа 78 хувьтай байна.

Мөн намрын ургац хураалтад 411 комбайн, 125 будаа цэвэрлэгч, 128 будаа ачигч, 10 төмсний комбайн, 5 даршны комбайн, 27 төмс ухагч, 32 хүнсний ногоо хураагч, 22 механикжсан үртрэм ажиллаж байна.

2021 оны ургац хураалтын явц бэлтгэл ажлыг газар дээр нь танилцан цаашид авах арга хэмжээ төлөвлөгөө боловсруулах Орхон, Орхонтуул, Сант, Хушаат зэрэг сумдын ургац хураалтын дүн мэдээтэй танилцлаа.

Улаанбаатар хотод жил бүр зохион байгуулагддаг “Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл 2021” нэгдсэн арга хэмжээнд аймгийн 31 ногоочин, хоршоо оролцож төмс 20 тн, 11 төрлийн хүнсний ногоо 60 тн, даршилсан ногоо 1000 шил, зөгийн бал 350 шилийг худалдан борлуулж нийт **116.530.000** төгрөгийн борлуулалт хийгдсэн байна.

Аймгийн хэмжээнд төмс, хүнсний ногоо хадгалах зориулалт бүхий 34.1 мян.тн-ы багтаамжтай зоорьтой. Энэ нь тухайн жилийн хураан авсан ургацын 28 хувийг хадгалах боломжтой байна.

Худалдааны салбар үүсч хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагааг сурталчилсан сэтгүүл гаргах ажил эхлэн Сүхбаатар, Түшиг, Цагааннуур, Зүүнбүрэн сумын иргэдийн зураг авалтыг хийгээд байна.

Засгийн газрын 2021 оны “2021-2022 оны мал өвөлжилт хаваржилтийн бэлтгэл ажлыг хангуулах тухай” 221 дугаар тогтоол аймгийн Засаг даргын 2021 оны “2021-2022

оны өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 01 дүгээр албан даалгаврын хүрээнд сумдад мал, мах бэлтгэлийн ажлыг эрчимжүүлэх, мал сүрэгт хийх намрын технологит ажлыг эрчимжүүлж үржилд тэнцэхгүй хээлтэгч хээлтүүлэгчийг үржлээс хасах, эр сувай малыг эдийн засгийн эргэлтэд оруулах, малчдын түвшинд бэлтгэх өвс тэжээлийн нөөц, сумын аюулгүйн нөөцөд бэлтгэх өвс тэжээлийн нөөцийг 100 хувь бүрдүүлэх зэрэг үүрэг чиглэл өгөн ажиллаж байна. Тус тогтоолын дагуу аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөцөд 100 тн өвс, 100 тн ногоон тэжээл, 100 тн үйлдвэрийн тэжээл, сум бүр аюулгүйн нөөцөд 100 тн өвс 30 тн хүчит тэжээл бэлтгэх үүрэг өгөгдсөн. 10 дугаар сарын байдлаар аймгийн нөөцөд бэлтгэвэл зохих 100 тн тэжээлийг “Алтан тариа” ХХК-тай цаг хүндэрсэн үед малчдад хөнгөлөлттэй үнээр олгохоор тохиролцон гэрээ байгуулаад байна.

10 дугаар сарын байдлаар 108.040 тн байгалийн хадлан, 2569 тн ногоон тэжээл, 537 тн дарш, 625 тн үйлдвэрийн тэжээл бэлтгээд байгаа нь нийт малчдын түвшинд бэлтгэх өвс тэжээлийн нөөц бүрдүүлэлтийн 50 хувь байна.

Баталгаажсан үүлдэр омгийн малд технологит хугацаанд нь намрын үзлэг ангилалт хийх ажилд үүрэг чиглэл, заавар хүргүүлэн үхэр сүрэгт хийх үзлэг ангилалтын ажил сумдад хийгдэж байна.

Байгаль орчны талаар: Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 дугаар хэсгийн 5.1.8 дахь заалт “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8 мянган га талбайг нөхөн сэргээнэ” гэсэн зорилт, БОАЖЯ-аас ирүүлсэн 2020 оны “Чиглэл өгөх тухай” 06/8786 тоот албан бичгийн хүрээнд аймгийн нутаг дэвсгэрт эвдэрч олон жил орхигдсон нөхөн сэргээлт хийгээгүй талбайгаас тодорхой хэмжээ бүхий талбайн нөхөн сэргээлтийг ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд төлөвлөн гүйцэтгүүлэхээр газар зүйн солбицлыг тодорхой зааж албажуулан ажилласан. Энэхүү ажлын хүрээнд 13 аж ахуйн нэгж, байгууллагын төлөвлөгөөнд 86.3 га талбайг тусгуулсан ба өнөөдрийн байдлаар 9 аж ахуйн нэгж, байгууллагын 59.8 га талбайд хийж гүйцэтгэсэн нөхөн сэргээлтийн ажлыг хүлээж авсан.

Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Баянгол сумын “Бороогоулд” ХХК, “Сонортрейд” ХХК, Түшиг сумын “Шар нарст” ХХК, Ерөө сумын “Болдтөмөр Ерөө гол” ХХК, “Ди Зэт энд Ай” ХХК, “Капитал авто сервис” ХХК зэрэг 6 аж ахуйн нэгж, байгууллага 2021 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн. Нөхөн сэргээлтийн ажлыг БОАЖ-ын Сайдын 2015 оны А/419 тоот тушаалын дагуу “Нөхөн сэргээлт хүлээж авсан тухай” акт үйлдэн хүлээж авч ажиллалаа.

Алтанбулаг, Цагааннуур, Сүхбаатар, Ерөө сумын Бугант тосгонд “Голын хамгаалалтын бүс 50 метр” гэсэн хамгаалалтын самбаруудыг байршуулан ажиллаж хүлээн авах комисс газар дээр нь хүлээн авч ажилласан. Алтанбулаг сумын Цантахын даваа нэртэй газарт “Өргөн Сэлэнгэ” ХХК, “Ойн хүрэм” ХХК, Цагааннуур сумын Шүрэнгийн ам нэртэй газарт “Ойн хүрэм” ХХК-ий орон нутгийн санхүүжилтээр ойжуулалтын ажлыг гүйцэтгэснийг хүлээн авч ажилласан.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/276 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2021онд Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар “Өргөн Сэлэнгэ” ХХК-ий Алтанбулаг сумын “Цантах” гэх газрын 70 га, “Ойн хүрэм” ХХК-ий 60 га, Баруунбүрэн сумын Шүрэн нэртэй газрын 70 га талбайд гүйцэтгэсэн ойжуулалтын ажлын биелэлт, гүйцэтгэлийг газар дээр нь шалгаж актаар хүлээн авч ажиллалаа.

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны А-96/71 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журам”-ын дагуу ойжуулсан талбайд тооллого явуулж амьдралын хувийг гарган актаар хүлээж авсан.

Мөн Алтанбулаг сумын мод бэлтгэгч нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагуудын өөрийн хөрөнгийн ойжуулалт, Япон улсын “GNC” ТББ-ын хөрөнгөөр хийсэн ойжуулалтын ажлыг шалгаж үнэлэлт, дүгнэлт өгсөн.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын талаар: 2021-2024 онд Европын Холбооны санхүүжилтээр “Хөдөө аж ахуйн менежмент, экосистемийн тогтвортой байдлыг хангах” төслийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон Ерөө, Мандал, Жавхлант сумдад “Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний ажлыг гүйцэтгэхээр болсон. Тус төслийн хэрэгжүүлэгч байгууллага Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүнс хөдөө аж ахуйн байгууллага, Германы хамтын ажиллагааны GIZSTREAM төслийн мэргэжилтнүүд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт ажиллалаа.

Уг ажилтай уялдуулан аймгийн Засаг даргын 2021 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/301 тоот захирамжаар “Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын даалгаврын төсөл боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсгийг томилж ажлын даалгаврын төслийг боловсруулан хөрөнгө оруулагчид хүргүүллээ.

ГХБХБГ-ын даргын 2021 оны “Газрын харилцаа-цахим шилжилт” аян зохион байгуулах тухай А/60 тоот тушаалаар баталсан удирдамжийн дагуу Сүхбаатар сумын төр төсвийн байгууллагын албан хаагчдад egazar гар утасны аппликейшн, www.egazar.gov.mn цахим хаягийг хэрхэн ашиглах талаар сургалт, сурталчилгаа, гарын авлагыг тарааж мэдээ, мэдээллээр хангаж ажиллалаа.

Барилга угсралтын ажилд ажил эхлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон байдал:

- Бетонон хучилттай зам тавих ажил 2021.09.28-ны өдрийн АЗ-70/2021 дугаартай зөвшөөрөл
- Ногоон байгууламж, зам талбайн тохижилт 2021.09.28-ны өдрийн ГТ-71/2021 дугаартай зөвшөөрөл
- Орхон 6-р багийн гудамжны гэрэлтүүлгийн ажил 2021.09.28-ны өдрийн ГГ-72/2021 дугаартай зөвшөөрөл
- Сүхбаатар сумын салхитын 3-р багийн гудамжны гэрэлтүүлгийн ажил 2021.09.28-ны өдрийн ГТ-73/2021 дугаартай зөвшөөрөл
- Баянхан 4-р багт тоглоомын талбай хийх ажил 2021.09.28-ны өдрийн ГТ-74/2021 дугаартай зөвшөөрөл
- Сүхбаатар сумын 1-р сургуулийн дотуур байрны засварын ажил 2021.09.28-ны өдрийн БЗ-75/2021 дугаартай зөвшөөрөл
- Сүхбаатар сумын Бор гүвээ 5-р багт тоглоомын талбай барих ажил 2021.09.28-ны өдрийн ГТ-76/2021 дугаартай зөвшөөрөл
- Ерөө сумын зам засвар, тэмдэг тэмдэглэгээний ажил 2021.10.18-ны өдрийн АЗ-77/2021 дугаартай зөвшөөрөл
- Сүхбаатар сумын 4-р сургуулийн хажууд авто зогсоол байгуулах ажил 2021.10.18-ны өдрийн АЗ-78/2021 дугаартай зөвшөөрөл
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын барилгын гадна фасад засвар 2021.10.19-ний өдрийн БЗ-79/2021 дугаартай зөвшөөрөл

- Түшиг сумын 1, 2 дугаар багт шороон зам засвар өргөтгөлийн ажил 2021.10.18-ны өдрийн АЗ-80/2021 дугаартай зөвшөөрөл
- Хүдэр сумын зам засвар, тэмдэг тэмдэглэгээний ажил 2021.10.18-ны өдрийн АЗ-81/2021 дугаартай зөвшөөрөл
- Сайхан суманд бичил хорооллуудын дунд ногоон байгууламж, тохижилт, авто зогсоол шинээр хийх, стандартад нийцсэн хогийн савтай болох ажил 2021.10.19-ний өдрийн ГТ-82/2021 дугаартай зөвшөөрөл
- Сант сумын зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, замын гэрэлтүүлгийн ажил 2021.10.21-ний өдрийн АЗ-83/2021 дугаартай зөвшөөрөл
- Хүдэр сумын төвд амралт, чөлөөт цагийн төв барих ажил 2021.10.21-ний өдрийн ГТ-84/2021 дугаартай зөвшөөрлийг тус тус гарган ажилласан.

Зургаа. Сум орон нутгийн ажил үйлчилгээний талаар:

Алтанбулаг сум:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар “НЭГ ТЭРБУМ” мод тарих үндэсний хөдөлгөөн, Монгол Улсад ойн салбар үүсгэн байгуулагдсаны 100 жилийн ойг угтаж аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, бэлчир бүсийн сум дундын ойн анги, Сэлэнгэ бүсийн сум дундын ойн анги, Орхон бүсийн сум дундын ойн анги, Ерөө бүсийн сум дундын ойн анги, Хараагийн бүсийн сум дундын ойн анги, Хүдэр сумын ойн ангиуд хамтран Алтанбулаг сумын Цөх 3 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах “Доргон толгой” гэх газарт 1 га талбайд Хуш-217, Шинэс-500, Нарс-1500 нийт 2217 тарьцын суулгацаар ойжуулалтын ажлыг хийлээ.

Аймгийн Засаг даргын 2021 оны “Бүх нийтийн ариутгал халдваргүйжүүлэлтийг эрчимжүүлэх тухай” А/15, сумын Засаг даргын 2021 оны “Бүх нийтийн хог цэвэрлэгээг зохион байгуулах тухай” А/197 тоот захирамжийн дагуу төр, төсвийн 7 байгууллага, худалдаа үйлчилгээний 50 газрын нийт 265,762 м² ариутгал халдваргүйтгэл хийж, бүх нийтийн хог цэвэрлэгээгээр нийт 25 тн хог хаягдлыг сумын төвийн нэгдсэн хогийн цэгт хаяв.

Аймгийн Засаг даргын 2021 оны “Үзэсгэлэн худалдаа зохион байгуулах тухай” А/307 дугаар захирамжийн дагуу Сүхбаатар суманд зохион байгуулагдсан “Сэлэнгэ ургац-2021” үзэсгэлэн худалдаанд тус сумаас 5 ногоочин чацарганы өтгөрүүлсэн шүүс, даршилсан ногоо, кимчи, салат, хүнсний ногоо зэрэг 20 гаруй төрлийн бүтээгдэхүүнээр оролцож, 2.400.0 төгрөгийн борлуулалт хийсэн.

1-10 дугаар сарын байдлаар сумын хэмжээнд нийт 331 тохиолдол бүртгэгдсэнээс 293 иргэн эмчлэгдсэн 35 иргэн гэрээр эмчлэгдэж, 3 иргэн нас барсан. Тус иргэдийн ойрын болон дам хавьтлыг тодорхойлох тандалт судалгааны ажлыг сумын Засаг даргын 2021 оны “Үүрэг болгох тухай” А/194 тоот захирамжийн дагуу “Хариу арга хэмжээг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажиллагаа-зохицуулах” багийн 12 гишүүн хариуцан ажиллаж байна.

Боловсрол Шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2021 оны А/292, А/525 дугаар “Коронавируст халдварын үед ерөнхий боловсролын сургуулийн хичээл сургалт зохион байгуулахад мөрдөх түр журам”-ын 2 дахь заалтыг баримтлан 2021-2022 оны хичээлийн жилд 792 сурагч, 67 багш, ажиллагсадтайгаар сургалтын үйл ажиллагаа эхэлсэн.

Сургуулийн өмнөх боловсролд нийт 303 хүүхэд хамрагдахаас 126 хүүхэд танхимаар хичээллэж байна.

Баруунбүрэн сум:

10 дугаар сарын байдлаар сумын хэмжээнд үр тарианы ургац хураалт 75 хувьтай, төмс, хүнсний ногооны хураалт дууссан байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны “Үзэсгэлэн худалдаа зохион байгуулах тухай” А/307 дугаар захирамжийн дагуу Сүхбаатар суманд зохион байгуулагдсан “Сэлэнгэ ургац-2021” үзэсгэлэн худалдаанд тус сумаас 3 иргэн төмс, хүнсний ногоо, цагаан идээний үзэсгэлэн худалдаагаар оролцож 10 гаруй сая төгрөгийн борлуулалт хийлээ.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын А/187 дугаар тушаалаар “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам” шинэчлэн батлагдсантай холбоотой аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас “Газрын харилцаа-Цахим шилжилт” нээлттэй хаалганы өдөрлөгийг тус суманд зохион байгуулж, өдөрлөгт сумын төр, төсвийн байгууллагын нийт 40 гаруй албан хаагч иргэд оролцож www.egazar.gov.mn, egazar аппликейшны талаар мэдээлэл сурталчилгаа хийж ажиллалаа.

Аймгийн Биеийн Тамир спортын газрын уриалгаар “Ажлын байрандаа дасгалаа хийж дархлаагаа дэмжье” аянд Баруунбүрэн сумын Спорт цогцолбор болон тус сумын Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн сурагчдын төлөөлөл оролцон видео бичлэгийг цахим хаягт байршуулан дараагийн байгууллагыг аянд нэгдэхийг уриаллаа.

10 дугаар сард сумын Эрүүл мэндийн төвөөс Коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх дархлаажуулалт “Комэрнэти” вакцины 3 дугаар тунд хамруулах ажлыг зохион байгуулж, нийт 500 иргэнийг дархлаажууллаа.

Мөн ерөнхий боловсролын сургуулийн 430 сурагч, 1-р цэцэрлэгийн 38 хүүхдэд урьдчилан сэргийлэх үзлэг хийж ажиллалаа.

Баянгол сум:

Сумын Засаг даргын 2020 оны “Шуурхай штаб байгуулж, ажлын тусгай горимд шилжүүлэх тухай” А/254 дүгээр захирамжийн дагуу Засаг даргын Тамгын газрын байранд шуурхай штабыг байрлуулан 24 цагийн хариуцлагатай жижүүрийг томилж, үүссэн нөхцөл байдалтай холбоотой мэдээ, мэдээллийг аймгийн Онцгой комисс болон холбогдох байгууллагад 94244802 дугаарын утсаар болон цахимаар буюу Bayangolshuurhaishtab@gmail.com хаягаар хүргүүлэн ажиллаж байна.

Сумын хэмжээнд /Ковид-19/ цар тахлын тархалт, өвчлөл ихэссэнтэй холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны 01/318, 01/357 тоот албан бичгүүдээр Улсын 1-р төв эмнэлэгийн ерөнхий захиралд хүсэлт тавьж эрүүл мэндийн салбарт тулгамдаж буй асуудлуудыг бууруулах, чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор мэдлэг, арга зүйн зөвлөгөө авч хамтын ажиллагааны харилцаа тогтоох асуудлыг шийдвэрлэлээ. Энэ ажлын хүрээнд 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс тус суманд 35 ортой Ковидын тасаг нээн 68 иргэн хэвтэн эмчлүүлсэн байна. Одоо тасагт 28 иргэн хэвтэн эмчлүүлж байна.

Улсын 1-р төв эмнэлэгийн мэргэжлийн багийг сумандаа урьж нөхцөл байдалтай танилцуулан эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах, бүрэн ашиглах, эмнэлгийн ажилчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, дадлагажуулах, чадваржуулах ажлын хүрээнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажлын байран дахь сургалтыг зохион байгууллаа.

10 дугаар сарын байдлаар 789 иргэн коронавирусын халдвар илрүүлэх түргэвчилсэн шинжилгээнд хамрагдан, ковидын 292 тохиолдлыг gerege.mn, tandalt.mn программд шивэн оруулсан.

“Хугацаат цэргийн албаны ээлжит татлага зохион байгуулах тухай” аймгийн Засаг даргын 2021 оны А/272, сумын Засаг даргын А/170 дугаар захирамжуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2-р ээлжийн хугацаат цэргийн албаны татлагад хамрагдах нийт 289 залуусын судалгааг гаргаж, 216 иргэнд “Цэргийн жинхэнэ албанд зарлан дуудах мэдэгдэл”-ийг биечлэн хүргэж, 17 иргэнд утсаар мэдэгдэж, 50 иргэнийг цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж 10 иргэн тэнцлээ.

Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны 479 тоот албан бичгийн хүрээнд “Хог биш мод таръя”, “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөрт нэгдэцгээе” цахим уриалга гарган сургууль, цэцэрлэгийн орчмын талбайд тарих шаардлагатай ногоон байгууламжийн зураг төслийн дагуу төр, төсвийн 7 байгууллагын 65 албан хаагчдын хамт Шар хуайс 20, Агч 66, Үхрийн нүд 10, Нохойн хошуу 22 нийт 118 ширхэг мод тарьсан. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Бүх нийтийн мод тарих өдөр”-ийг зохион байгуулан төр төсвийн 7 байгууллагын 65 албан хаагч, “Цахиурт Ресурс” ХХК-тай хамтран Хүүхэд залуучуудын хөгжлийн төвийн талбайд 200 ш чацаргана, 200 ш үхрийн нүдний суулгац, “Хонгорын орд” ХХК Баян багийн зам дагуу 2 га газрыг хашаажуулан 155 ш улиас мод, “Бороо гоулд” ХХК нь дүйцүүлэн нөхөн сэргээх ажлын хүрээнд элсний нүүдэл болон цөлжилтөд өртсөн Хараа багийн Бор толгой гэх газар хамгаалалтын зурвас байгуулах болон ойжуулалт байгуулах төсөлт ажлын хүрээнд хийж хэрэгжүүлж байгаа 45,6 га талбайдаа 30000 мод бутыг тус тус тарьж цаашид ховор болон нэн ховор ургамал тарих төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Цахим системийн гэрчилгээ бичилтэд цаг тухай бүрт хяналт тавин баталгаажилт хийж 09 дүгээр сарын 21-ээс 10 дугаар сарын 21-ний өдөрт 28346 кг мах, 10150 литр сүүнд 75 цахим гэрчилгээ бичигдсэн байна.

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 “В”, 29.1.6 “г” дэх заалт, Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.10 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 01 тоот албан даалгавар, сумын Засаг даргын 2021 оны “Золбин нохой, муур устгах ажлыг зохион байгуулах” А/164 тоот захирамжийн хүрээнд Хараа, Баян, Гонир 3 багийн төвийн хэсгийн 104 золбин нохойг утсгаж, булшлан ариутгал халдваргүйтгэлд хяналт тавин ажиллалаа.

10 дугаар сарын байдлаар улаанбуудай 5042 га талбайг ангилан хадаж, 4237 га талбайг цайруулан 6500 тн буудай, шуудаар 842 га талбайг хурааж 1360 тн, нийт 5079 га талбайгаас 7860 тн ургац хурааж, 2975 тн буудайг гурлын үйлдвэрт, 325 тн ХААДС-д, 185 тн будааг спиртын үйлдвэрт тушаасан.

Хөдөө аж ахуйн салбарын 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд малчид, мал бүхий иргэдийн хадлан өвс бэлтгэлд хяналт тавьж, сумын фонд бүрдүүлэх ажилд анхаарал хандуулан ажиллаж байна.

Ерөө сум:

Аймгийн Засаг даргын 2021 оныг “Чанарыг эрхэмлэх жил болгох тухай” А/01, сумын Засаг даргын “Чанарыг эрхэмлэх жил болгон зарласантай холбогдуулан ажлын хэсэг байгуулах тухай” А/24 тоот захирамжуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн 1-5-р ангид “Эрүүл аюулгүй орчин”, 6-8-р ангид “Миний ирээдүй” сэдэвт гар зураг, 9-12-р ангид “Ирээдүйн Ерөө” эссэ бичлэгийн уралдааныг тус тус зарлаж нийт 67 бүтээл ирснээс шагналт 3 байр эзлүүлэн өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа. Мөн жилийн хүрээнд “Нээлттэй хаалганы” өдөрлөгийг

цахимаар зохион байгуулж, Улсын бүртгэл, Нийгмийн даатгал, Хөдөлмөр халамж, Татварын чиглэлээр иргэдэд мэдээ мэдээллийг өгч 46 иргэн мэдээлэл авсан байна.

Төсвийн 387213.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй Бугант тосгоны төв доторх зам засварын ажлыг “Сэлэнгэ Есөн Эрдэнэ” ХХК, мөн орон нутгийн хөгжлийн сангийн 70,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн сумын цэвэрлэх байгууламжийг “Эколос” ХХК суурилуулан 100 хувийн гүйцэтгэлтэй хүлээлгэн өглөө.

Аймгийн Засаг даргын А/272, сумын Засаг даргын А/218 тоот “Хугацаат цэргийн албаны ээлжит татлага зохион байгуулах тухай” захирамжуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2-р ээлжийн цэрэг татлагад нийтдээ 18-34 насны 132 иргэнд зарлан мэдэгдэх хуудас тарааснаас эмнэлгийн үзлэгт 37 залуучууд хамрагдаж 5 залуу цэргийн жинхэнэ албанд тэнцсэн байна.

10 дугаар сарын байдлаар сумын хэмжээнд Коронавируст /Ковид-19/ цар тахлын 97 тохиолдол батлагдаж түүнээс 38 иргэн эмчлэгдэж, 38 иргэн гэрийн ажиглалтад байна. Одоогоор Эрүүл мэндийн төвийн Ковидын тасагт 19, аймгийн Нэгдсэн эмнэлэгт 2 иргэн хэвтэн эмчлүүлж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн 40 сурагч Коронавируст /Ковид-19/-ын халдвар авч эмчлэгдсэн бөгөөд 70 сурагч ойрын хавьтал болсон байна.

Монгол Улсад Залуучуудын байгууллага үүсч хөгжсөний түүхт 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд “Ерөөгийн хөгжилд залуучуудын оролцоо чуулга уулзалт”-ыг зохион байгуулж танхимаар 30, цахимаар 22 оюутан залуучууд хамрагдсан байна.

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 3 багийн 650 гаруй иргэн 19692 тн хадлан бэлтгээд байна. Мөн сумын өвс тэжээлийн фондод 2900 боодол буюу 58 тн өвс нөөцлөөд байна. Намрын ургац хураалтын явц нийт 9642 га-д улаан буудай тариалсанаас 8171 га-с 10472 тн улаан буудай хурааж, ургац хураалт 84 хувьтай байна.

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 63 дугаар зарлиг, Аймгийн Засаг даргын А/138, сумын Засаг даргын А/90 тоот захирамжуудын хэрэгжилтийг хангах зорилгоор “БҮХ НИЙТЭЭР МОД ТАРИХ” үндэсний өдрийн арга хэмжээг зохион байгуулж 25 байгууллагын 220 албан хаагч хамрагдаж 146 нарс модыг тарьялаа. Мөн айл өрхүүдийн дунд “Нэг өрх таван мод” аяныг зохион байгуулж 52 өрхийн 110 иргэн нийт 420 ширхэг модыг хашаандаа тарьсан.

Жавхлант сум:

2021 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагат цэргийн насны 27 иргэнийг ариутгал халдваргүйжүүлэлтийн горимыг чанд сахин, улс, аймгийн Онцгой комиссын шийдвэрийг мөрдөн эмчийн үзлэгт хамруулан цэргийн насны 9 иргэн цэргийн албанд тэнцсэн.

Европын Холбооноос Монгол Улсад суух Элчин сайд Аксель Никэйз, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Дэд сайд Ц.Батбаяр, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Суурин төлөөлөгч Винод Ахужа, Германы ОУ-ын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ийн Суурин төлөөлөгч Даниел Пассон болон “Дэлхийн Зөн Монгол” ОУБ-ын төлөөлөгчдийн хамтаар Жавхлант сумын Засаг даргатай албан ёсны уулзалт зохион байгууллаа.

СТРИЙМ төсөл нь “Монгол улсад хүнсний тогтолцоо, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд шинэлэг, тогтвортой, ландшафтын түвшний менежментийг хэрэгжүүлэх чадавхыг нэмэгдүүлэх” зорилготойгоор тус суманд 2021 оноос 2024 он хүртэл 3 жилийн хугацаатай хэрэгжих юм.

“Жавхлант буудай” ХХК-ий 82 га улаан буудай болон 128 га рапс тариалсан нийт 210 га газарт Бумбат 1-р багийн иргэн Б, А, Б, Г, Б нарын 100 гаруй адуу орж идэж

сүйтгэж талхалсан гэх гомдлын дагуу сумын ЗДТГ-ын ургацын хохирол тогтоох ажлын хэсэг ажиллаж хяналт шалгалтаар зөрчил гаргасан 5 иргэнд Зөрчлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 8 дах заалтийг үндэслэн торгууль ногдуулж 1.500.000 төгрөгийн орлогыг Төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн.

Мөн аймгийн хөрөнгөөр хийгдэж буй Моностой, Бумбат багуудад малын худгийг “Сүлд хамба” ХХК, сумын төвийн гэрэлтүүлэг нэмэгдүүлэх ажлыг “Хайтек” ХХК гүйцэтгэсэн.

Сурагчдийн сурах таатай орчныг бүрдүүлж, шинжлэх ухаанч танин мэдэхүйн чадварыг нэмэгдүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуульд биологийн хичээлийн 82 нэр төрлийн 237 ширхэг 14,556.300 төгрөгийн үнэ бүхий сургалтын хэрэглэгдэхүүнтэй боллоо.

Сумын хэмжээнд 7870 га-аас 8380 тн улаанбуудай, 17 га-гаас 220 тн төмс, 124 га-аас 1720 тн хүнсний ногоо, 30 га-аас 80 тн овъёос, 150 га-аас 210 тн ногоон тэжээл, 1486 га-аас 430 тн тосны ургамал тус тус хураан аваад байна. Үр тарианы хураалт 95 хувьтай, төмс, хүнсний ногооны хураалт 100 хувийн явцтай байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар жил бүрийн тав, аравдугаар сарын хоёр дахь долоо хоногийг “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” хэмээн зарласан билээ. Тус арга хэмжээг хэрэгжүүлэх мөн “Тэрбум мод тарих аян”, “Байгаль хамгаалах сарын аян”-ны хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагын албан хаагчид сумын “Ойн зурвас”-д улиас, хайлаас нийт 1500 ширхэг навчит төрлийн мод тарьлаа.

Зүүнбүрэн сум:

Сумын Шуурхай штаб нь баталсан хуваарийн дагуу өдөр бүр гэрийн тусгаарлалт болон ариутгал халваргүйжүүлэлтийн мэдээг аймгийн Мэргэжлийн хяналтын газарт утсаар болон цахимаар хүргүүлэн ажиллаж байна.

Төрийн байгууллагуудын албан бичиг хэргийг 2022 оноос эхлэн крилл болон Монгол бичгээр хөтлөн явуулах туршилтыг явуулж, 2025 оноос эхлэн нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх болсонтой холбогдуулан бэлтгэл ажлыг хангуулахаар сумын Засаг даргаас “Хэлний бодлогын салбар зөвлөл” байгуулах тухай А/109 тоот захирамж гаргалаа. Захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Үндэсний бичиг-Зүүнбүрэн” цахим хуудас нээн Үндэсний бичгийг сурталчилж байна.

Мод тарих аянд төр, төсвийн 5 байгууллагын албан хаагчид нэг өдрийн цалин, үйлчилгээний байгууллага, ойн нөхөрлөл, иргэд сэтгэлийн хандив өгч Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэн “Зүүнбүрэн сумын хүүхэд залуучуудын цэцэрлэгт хүрээлэн”-д Гацуур 60, Нарс 60, Голт бор 20, Агч 50 нийт 190 ширхэг мод тарьлаа.

Насан туршийн боловсрол, Монгол хэл, уран зохиолын багш нар хамтран Сэлэнгэ аймгийн иргэдэд “Ажлын шаардлага, хувийн намтар, эрүүл амьдрахуй” сэдвээр ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын зохион байгууллаа. Уг сургалтад сум бүрээс 5, 5 иргэн оролцож 80 гаруй иргэн хамрагдсан байна.

Хүйтний улирал эхэлж байгаатай холбогдуулан сумын Засаг даргаас сурагчдыг тээвэрлэх ажлыг зохион байгуулах чиглэлийг 2021 оны 10 дугаар сарын 14-ний 01/265 тоотоор Ерөнхий боловсролын сургуулийн захиралд хүргүүлсний дагуу 168 өрхийн 1-5-р ангийн 214, 6-12-р ангийн 74 сурагчдийн эцэг эхээс судалгаа авах ажлыг зохион байгууллаа.

Газрын харилцааны 17 төрлийн үйлчилгээг цахимаар авдаг болсонтой холбогдуулан “Газрын харилцаа-Цахим шилжилт” аяны хүрээнд аймгийн ГХБХБГ-аас зохион байгуулж буй “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг зохион байгуулж

www.egazar.gov.mn вэб хуудас, egazar апплэйкешний талаар 120 гаруй иргэдэд сурталчилснаар 5 нэгж талбарын цахим гэрчилгээг үүсгэн egazar.mn сайтаас газар эзэмших эрхийн гэрээ, гэрчилгээ, кадастрын зургийг хэвлэж өглөө.

Мандал сум:

Аймгийн Засаг даргын 2021 оны “Хугацаат цэргийн албаны ээлжит татлага зохион байгуулах тухай” А/272, сумын Засаг даргын 2021 оны “Цэргийн албаны ээлжит татлага зохион байгуулах тухай” А/213 тоот захирамжийн дагуу 2021 оны хоёрдугаар ээлжийн цэргийн жинхэнэ албаны татлагыг 10 дугаар сарын 06-08-ны өдрүүдэд зохион байгуулж 18-25 насны 250 бэлтгэл үүрэгтнийг эрүүл мэндийн үзлэгт хамрууллаа.

Европын холбоо, Холбооны бүгд Найрамдах Герман Улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам, Германы олон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэг, Нэгдсэн үндэсний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Олон Улсын их сургуулиудын консорциумаас хамтран хэрэгжүүлж буй “Хөдөө аж ахуйн менежмент, экосистемийн тогтвортой байдлыг хангах төсөл” тус суманд нь 3 жилийн хугацаатайгаар хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан Европын Холбооноос Монгол Улсад суух Элчин сайд Аксель Никэйз, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Дэд сайд Ц.Батбаяр, Германы олон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ийн Суурин төлөөлөгч Даниел Пассон, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Суурин төлөөлөгч Винод Ахужа, Европын сэргээн босголт, хөгжлийн банкны төлөөлөгчид болон “Дэлхийн Зөн Монгол” ОУБ-ын үндэсний захирал нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг сумын удирдлагуудтай албан ёсны уулзалт хийлээ.

Дэлхийн болон Монголын багш нарын өдрийг тохиолдуулан сумын хэмжээнд “Сурагчийн нэг өдөр” арга хэмжээг зохион байгуулан, шинэ санал санаачлага гарган хамт олноо манлайлан төрийн дээд одон, медалиар шагнагдсан багш, ажилчдад шагнал гардууллаа.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Нийслэлийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран зохион байгуулсан “Оролцоод хөгжье” хүүхдийн үндэсний цахим чуулганд Сэлэнгэ аймгийг төлөөлөн “Хүслийн хөтөч” хүүхэд оролцооны клубын гишүүд оролцож санал бодлоо илэрхийллээ.

“Дэлхийн охидын өдөр”-ийг тохиолдуулан “Хүслийн хөтөч” хүүхэд хамгаалал, оролцооны клубээс “Охидын илтгэлийн цахим уралдаан”-ыг зохион байгуулан 15 охидын илтгэлээс шалгаруулалт хийж, мөн “Охидод нийтлэг тулгамддаг сэтгэл зүйн болон нууцлалын талаарх асуудлууд, шийдвэрлэх арга зам” сэдвийн хүрээнд “Охидын нээлттэй хэлэлцүүлэг”-ийг цахимаар зохион байгуулан хэлэлцүүлгээс гарсан санал, санаачлагын сумын Засаг даргад хүргүүллээ. Мөн “Хүслийн хөтөч” хүүхэд хамгаалал, оролцооны клубээс Мандал, Баянгол сумдын ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн 300 гаруй сурагчдад өсвөр үеийнхний ажил мэргэжлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн ертөнцтэй таниулах мэргэжлээ зөв сонгоход нь туслах зорилгоор “Мэргэжил сонголт” цахим сургалт зохион байгууллаа.

Цагдаагийн ерөнхий газар, хууль зүйн яамны дэргэдэх “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл”, Нийслэлийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас хамтран “Түр хамгаалах байрны үйл ажиллагаа, үйлчилгээний маягтууд”-д хийсэн хөндлөнгийн шалгалтаар “Хангалттай” дүгнэгдлээ.

“Кристиан Нобле” сангийн хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөрийн багийнхантай хамтран зорилтот 10 өрхийн 18 насанд хүрэгч 50 хүүхдэд урьдчилсан тандалт хийж, танилцуулан өрх тус бүрт хүнс, хувцасны тусламж үзүүлэхэд холбон зуучиллалаа.

Бага насны сурагчдын унших чадварыг нэмэгдүүлэх, номтой нөхөрлүүлэх зорилгоор “Би уншиж ойлгосноо ярьж чадна”, “Өвөрмөц нэгэн захидал” цахим уралдааныг цэцэрлэгийн бэлтгэл бүлэг, 1-р ангийн уншигчдын дунд зохион байгуулсан. Мөн “Урилгат уншлага” ном уншлагын аян, “Мөрөөдлийн ном-2021” зорилтот бүлгийн хүүхдүүдийг номтой нөхөрлүүлэх аянуудыг зохион байгуулж 185 хүүхдийг хамруулсан.

УИХ-ын гишүүн Ч.Ундрам, сумын Засаг дарга Н.Лхагвадорж нарын санаачлага, дэмжлэгээр дэвшилтэт технологийн чадамж бүхий “Компьютер томографийн аппарат” суурилуулагдаж, орон нутгийн иргэдэд оношилгоо шинжилгээг цаг алдалгүй хийж, тэдэнд учирдаг хүндрэл чирэгдлийг 70 хувь хүртэл бууруулах боломж нөхцөл бүрдлээ.

“Сэлэнгэ Мандал Номын сан” цахим хуудсаар дамжуулан иргэдэд зориулсан ном сурталчилгааны болон танин мэдэхүйн, орон нутгийн түүхийн мэдээлэл бүхий 9 төрлийн 117 мэдээллийг байршуулж, хүргэлээ.

Сумын Засаг даргын 2021 оны “Хадлангийн талбай ашиглалтыг сайжруулах тухай” А/168 тоот захирамжийн дагуу 250 малчин, мал бүхий өрх, 3 аж ахуй нэгж байгууллагатай гэрээ байгуулан 15100 тн байгалийн хадлан, 30 тн дарш, ногооны хаягдал бэлтгэсэн.

2021-2022 оны мал өвөлжилт хаваржилтын бэлтгэл хангах зорилгоор сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 100 тн өвс, 30 тн тэжээл нөөцлөхөөр бэлтгэл хангаад байна.

2021 онд сумын хэмжээнд 53 аж ахуйн нэгж байгууллага 1050 өрх газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байна. Үр тариа 7143,8 га, үүнээс 6861,8 га талбайд улаанбуудай, 282 га талбайд бусад үр тариа тариалж 4842 га талбайгаас 5410 тн ургац хураан авч “Улаанбаатар гурил” ХХК-д 3 аж ахуйн нэгж байгууллага 450 тн, “Спирт бал бурам” ХХК-д 5 аж ахуйн нэгж байгууллага 643 тн улаанбуудай нийлүүлээд байна.

Сумын Засаг даргын 2021 оны “Хадлан, тариалангийн талбайн ургац хамгаалах тухай” А/99 тоот захирамжаар малчдын өвөлжөөнд орох хугацааг 10 дугаар сарын 15-ны өдрөөр тогтоосныг намрын ургац хураалтын ажил цаг агаарын төлөв байдлаас шалтгаалан удааширч байгаа тул “Малчдын өвөлжөөнд орох хугацааг сунгах тухай” А/222 тоот захирамжаар 10 дугаар сарын 31-ны өдөр хүртэл сунгаж, малчид мал бүхий өрхүүдэд танилцуулан ажиллалаа.

Төв суурин газрын хүн амыг төмс, хүнсний ногоогоор хангах зорилгоор Улаанбаатар хотын 8 цэгт 52 иргэн 08 дугаар сарын 06-наас 10 дугаар сарын 10-ыг дуустал үзэсгэлэн худалдаанд оролцлоо. Баянзүрх дүүрэг Дүнжингарав худалдааны төвд “Ширхэнцэг өгөөж” хоршооны 11 гишүүн төмс, хүнсний ногооны үзэсгэлэн худалдаанд 8 дугаар сараас 11 дүгээр сарын 01-ийг хүртэл үзэсгэлэн худалдаанд оролцож байна.

Сумын хэмжээнд шимэгчлэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 2294 толгой мал амьтныг хамруулж ариутгал халдваргүйжүүлэлтийг 4550 м2 талбайд хийсэн.

Мах махан бүтээгдэхүүний мал эмнэлгийн магадлан шинжилгээний QR код олгох ажлыг нэвтрүүлэх зорилгоор мах бэлтгэлийн төвд ажлын 8 цагаар мал эмнэлэг үйлчилгээний нэгжүүд магадлан шинжилгээний QR код олгож нийт 84 ширхэг магадлан шинжилгээний гэрчилгээ бичигдлээ.

Тарни 8-р багт эмч, цагдаагийн 2 айлын орон сууц барьж ашиглалтад оруулахад бэлэн болоод байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй гудамж, замын гэрэлтүүлгийн ажил 90 хувьтай үргэлжилж байна.

Сумын төвд 1,1 км бохир усны шугам барих ажлыг “Алтайн үндэс констракшн” ХХК хуваарийн дагуу гүйцэтгэж, ашиглалтад хүлээлгэн өглөө.

Төмөр замчдын 1 дүгээр багийн 45, 43-р байрны урд талбайн 2300 м² автозам, зогсоолыг цемент бетон хучилттай болгож орчин нөхцөлийг сайжрууллаа.

Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар хэрэгжиж буй “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 63 дугаар зарлиг, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн-ний хүрээнд сумын хэмжээнд “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг зохион байгуулж 46 аж ахуй нэгж, байгууллагын 521 хүн идэвхтэй оролцон Хараа голын эрэг дагуу 320 ширхэг, байгууллагын гаднах тохижилтод 1719 ширхэг нийт 2039 ширхэг мод, бут сөөг тарьсан. Тус 46 аж ахуй нэгж, байгууллага нийтийн эзэмшлийн талбайд таригдсан модонд арчилгаа, усалгаа хийж 2533 м урт хайсыг сэргээн засварлалаа.

Сумын Засаг даргын Тамгын газрын гаднах соёмбот талбайд үзэсгэлэн худалдаа зохион байгуулж 2 аж ахуйн нэгж байгууллага, 3 нөхөрлөл, 5 иргэн 16 төрлийн мод, бут сөөг, хүнсний ногоо зэрэг бүтээгдэхүүнээр оролцлоо.

Сумын хэмжээнд өвөлжилтийн түлшний бэлтгэлийг хангах үүднээс 11 мэргэжлийн байгууллагад үүрэг өгсний дагуу 9 ойн мэргэжлийн байгууллага одоогийн байдлаар 591,19 м³ түлшний модыг доод агуулахад татан төвлөрүүлээд байна. Сумын төвийн багуудаас хөнгөлттэй үнээр түлээнд хамрагдах 159 иргэдийн нэрсийг авч 11 сараас түлээ тараах бэлтгэл ажлыг ханган ажиллаж, 17 иргэнд үнэгүй түлээ олголоо.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны “Ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэх самрын нөөцийг тогтоож зөвшөөрөл олгох тухай” 28 тоот тогтоолоор үйлдвэрлэлийн зориулалтаар 2000 тн, ахуйн зориулалтаар 846,2 тн-ийг баталсан. Үүний хүрээнд 18 мэргэжлийн байгууллагатай 2000 тн “Хуш модны самар бэлтгэх” гэрээг байгуулж, 760 тн зөвшөөрөл олгож ажиллалаа.

Орхон сум:

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 20 тоот тогтоол “Ногоон төгөл хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хүрээлэн буй орчин, байгаль дэлхийгээ хамгаалах, эрүүл аюулгүй ногоон орчныг бүрдүүлэх зорилгоор нийт 92 ширхэг мод butыг тарьж суулгалаа. Үүнд: Хайлаас, Чацаргана, Агч, Улиас, Үхрийн нүдний суулгацуудыг тарих ажлыг хийж гүйцэтгэсэн. Тус ажилд төр төсвийн 21 албан хаагч, хувийн хэвшлийн 10 ажилтан нийт 31 иргэн оролцсон.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 08 тоот тогтоолын дагуу Орхон сум Баруунбүрэн сумаас түлшний зориулалтаар 2000 м³ Шинэс мод, өөрийн сумаас 50 м³ Бургас бэлтгэх хуваарь батлагдсан. Баруунбүрэн сумаас 30 иргэн 120 м³ түлшний мод, 20 иргэн 80 м³ гишүү бэлтгэж тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавин ажилласан.

Сумын төв хогийн цэгийн 2 га газрын хог хаягдлыг түрж, булах ажлыг зохион байгуулсан.

Хөдөө аж ахуйг дэмжих санд 1000 тн, “Улаанбаатар гурил” ХХК-д 200 тн, “Алтан тариа” ХХК-д 70 тн, “Од” гурилын үйлдвэрт 350 тн улаанбуудайг тус тус борлуулаад байна.


Аймгийн төв Сүхбаатар суманд зохион байгуулагдсан “Сэлэнгэ ургац-2021” үзэсгэлэн худалдаанд 2 иргэн сүү цагаан идээ, буриад гутлын төрлөөр оролцож 355.000 төгрөгийн борлуулалт хийсэн.

Сумын Засаг даргын 2021 оны “Малчдын өвөлжөөнд буух хугацааг сунгах тухай” А/100 тоот захирамжийн хүрээнд малчин, мал бүхий 88 өрхөд зөвлөмж, мэдэгдэл хүргэсэн.

Тарималын төрөл	Тариалсан талбай га	Хураасан талбай га	Хураасан ургац тн	Га-ийн ургац цн	Ургац алдсан талбай га	Хураалтын явц
Улаан буудай	8959	8193	8737	9		91
Бусад үр тариа	237	237	308,1	13		100
Тосны ургамал	2912	2812	757	3		96
Тэжээлийн ургамал	1469	1445	1950,75	13,5	24	100
Төмс	370	270,05	3240	120	99,95	100
Хүнсний ногоо	263	163,8	2081,4	120,7	50,8	100
Бэлтгэсэн уринш	11380					

/Ургац хураалтын явцыг хүснэгтээр харуулав./

Сумын хэмжээнд нийт 112979 мал, хонинд толгойд шилжүүлснээр 210590 тол.мал өвөлжихөөр урьдчилсан тооцоог гаргасан. 2021 онд малын тэжээлийн болон бизнесийн зориулалтаар хадлан бэлтгүүлэхээр 341 иргэнтэй 11665 га талбайд хадлангийн гэрээ байгуулсан. Нийт бэлтгэсэн хадлан 9481 тн, гүйцэтгэл 95.6 хувьтай байна. Үүнээс малын тэжээлийн зориулалтаар нийт бэлтгэвэл зохих өвсний 98.2 хувь буюу 7281 тн өвс, бизнесийн зориулалтаар бэлтгэвэл зохих өвсний 87,7 хувь буюу 2200 тн өвс бэлтгээд байна. Нийт хадлан бэлтгэл 95.6 хувьтай байна.



Хүнс Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөлтэй хамтран зохион байгуулсан хонин сүргийн махны гарцыг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн эргэлтэд оруулах арга хэмжээний хүрээнд аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын “Мал үржлийн алба”-тай хамтран Францын махны үүлдрийн түргэн өсөлттэй нарийн ноост үүлдрийн 26 хуцыг 23 малчин өрхөд хүлээлгэж өгсөн.

Орхонтуул сум:

Сумын Засаг даргын 2021 оны А/123 тоот захирамжийн дагуу нийт төр, төсвийн байгууллагуудад Засаг даргын нэрэмжит үзлэгийг зохион байгуулж, үзлэгт нийт 7 байгууллага хамрагдаж удирдамжийн дагуу 8 чиглэлээр шалгаж зөрчил, алдаа дутагдлыг засч сайжруулах, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажиллалаа.

Малын гоц халдварт “Шүлхий” өвчний шинж тэмдэг Баянцогт 2-р багт илэрсний дагуу Сумын Онцгой комисс шуурхай хуралдаж бүх малчдын судалгаа гарган холбогдож сэрэмжлүүлэг өгч, “Салхитын Хар хошуун”-д хяналтын пост гарган, шуурхай штабыг 24 цагаар ажиллуулан яаралтай арга хэмжээг авч ажиллаж байна.

Сумын иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын дагуу өвөлжөөний газрын асуудлаар малчин, мал бүхий иргэдээр хяналт шалгалт хийж нийт 8 айлд зөрчил арилгах мэдэгдэл хүргүүлэн ажиллалаа.

Orkhontuul@se.gov.mn цахим хуудас, Орхонтуул ЗДТГ фэйсбүүк хуудсаар дамжуулан иргэдэд Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль, Хүүхдийн аюулгүй байдлыг ахуйн орчинд хэрхэн хангах талаарх мэдээ мэдээллийг тогтмол, түгээн ажилласан.

10 дугаар сарын байдлаар нийт 122 цахим гарал үүслийн гэрчилгээнд хяналт тавьж баталгаажуулсан байна. Үүнд: Амьдаар адуу 40, үхэр 55, хонь 452, ямаа 270 нийт 817 мал амьтан хүнсний зориулалтаар бичигдсэн байна.

Сайхан сум:

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль болон Үндэсний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжоор тус тус нийт албан хаагчдад танилцуулга хийгдлээ.

2021 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлага Соёлын ордонд зохион байгуулагдаж Орхон, Сант, Баруунбүрэн, Орхонтуул сумдын 18-25 насны цэргийн насны залуучууд цэрэг татлагад хамрагдлаа.

Аймгийн Засаг даргын Авлига, ашиг сонирхлын болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай 01/1077 тоот албан бичгийн дагуу “Шударга удирдагч, шударга төрийн албан хаагч” аяны удирдамжийг нийт албан хаагчид болон төр, төсвийн байгууллагуудад хүргүүлэн, 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд нь тусгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

10 дугаар сард Байгаль орчны хяналтын чиглэлээр сум дундын Цагдаагийн хэлтэстэй хамтарсан төлөвлөгөөт хяналт шалгалт 1 удаа, төлөвлөгөөт бус хяналт шалгалт 2 удаа тус тус зохион байгуулсан. Хяналт шалгалтын хүрээнд эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй газрын хэвлий ашигласан 1 иргэнд, зөвшөөрөлгүй газар ашигласан 1 иргэнд тус тус Зөрчлийн тухай хуулийн дагуу нийт 350.000 төгрөгийн торгууль шийтгэлийн арга хэмжээ авсан байна.

Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 2, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 1 аж ахуйн нэгж байгууллагын 2021 оны Байгаль орчны менежмент төлөвлөгөөг баталж, тайлан мэдээг аймгийн Мэргэжлийн хяналтын газарт хүргүүлсэн болно. Сайхан суманд үйл ажиллагаа явуулдаг ойн мэргэжлийн байгууллага болох “Хэт-Жолоо” ХХК-ий бэлтгэсэн 35 м3 мод модон материалын тээвэрлэлтэд гарал үүслийн гэрчилгээ олгон ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар 2030 он хүртэл тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөнд нэгдэн Номгон тосгонд цэцэрлэгт хүрээлэнд Улиас, Агч нийт 32 ширхэг мод тарисан байна. Мөн тосгоны иргэдэд хашаандаа мод тарих уриалга өрнүүлж 100 ширхэг Улиас, Агч модны суулган тарилаа.

Сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг Хадлангийн талбайн ашиглалтын гэрээний 4.1 дэх заалтад заасны дагуу тухайн гэрээ байгуулсан малчин, мал бүхий иргэд 4500 орчим өвс тушаахаар харилцан тохиролцож тодорхой 2 цэгт байршуулж байна.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих “Ногоон байгууламж, зам талбайн тохижилт”- ын ажлын гүйцэтгэлд байнгын хяналт тавин, нэмэлт ажлын саналыг гүйцэтгэгч байгууллагад хүргүүлэн ажиллаж байна. Тус ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Дөмбөн 4-р багийн нутаг дэвсгэрт хэрэгжиж буй Бичил хорооллуудын дунд тохижилт, ногоон байгууламж, авто зогсоол шинээр хийх ажилд хяналт тавин ажиллаж байна.

Улсын хэмжээнд охидын эрхийг хангах, хамгаалах чиглэлээр ажилладаг “Гүнж” төвөөс санаачлан зохион байгуулсан “Дижитал эрин ба охид” хэлэлцүүлэгт 6-12-р ангийн анги бүрийн төлөөлөл 20 эмэгтэй сурагч оролцож мэдээ, мэдээлэлтэй болсон.

Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны 584 тоот албан даалгавараар Сайхан суманд “Хугацаат цэргийн албаны татлага”-т хамрагдах залуучуудыг 10 дугаар сарын 08-10-ны өдрүүдэд эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулсан. Нийт 212 залуус эрүүл мэндийн үзлэгт орсон. Үүнээс төрөлхийн гажиг 7, эмчийн хяналтад байгаа 13, гэмтлийн шалтгаант өөрчлөлттэй 12 хүн илрүүлж, эмчилгээ хяналтад авсан.

10 дугаар сарын байдлаар нийт 442 Коронавируст халдварын тохиолдол батлагдсан. Үүнээс гэрийн эмчилгээнд 202 хүн хамрагдан эмчилгээний хугацаа дуусаагүй 149 иргэн гэрийн хяналтад байна. Халдвартын тасагт нийт 234 хүн хэвтэн эмчлэгдсэн. 3 хүний биеийн байдал хүндэрч аймгийн Нэгдсэн эмнэлгийн эрчимт эмчилгээний тасагт шилжүүлсэн. Мөн 85 настай иргэн Коронавируст халдварт өвчин хүнд хэлбэр, тархины цус харвалт өвчний учир 10 хоног хэвтэн эмчлүүлж байгаад нас барсан.

Сумын Засаг даргын 2021 оны 1/479 дугаартай албан тоотын дагуу 21 дүгээр байрны ард 58 метр явган хүний замын хавтан тавьж, хашлага цутгасан болно. Мөн 21 дүгээр байрны хойд хэсэгт явган хүний зам дагуу ногоон байгууламжийн хайс татах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Сант сум:

Сумын хэмжээнд ургац хураалтын ажил 10 дугаар байдлаар: Үр тариа 2115,6 га талбайгаас 3316 тн буюу нэгж га талбайгаас 15,6 цн, ургац хураалт 94.9 хувьтай, тосны ургамал 1103 га талбайгаас 492.6 тн буюу нэгж га талбайгаас 4,4 цн, ургац хураалт 68,7 хувьтай, тэжээлийн ургамал 696.7 га талбай хураахаас 177 га талбайд мал орж ургац хураах боломжгүй болсон. 300 га талбайгаас 450 тн буюу нэгж га талбайгаас 15 цн ургац, ургац хураалт 57,7 хувьтай, төмс 180 га талбайгаас 1800 тн буюу нэгж га талбайгаас 100 цн ургац, ургац хураалт 100 хувьтай хүнсний ногоо 122 га талбайгаас 1240 тн буюу нэгж га талбайгаас 101 цн ургац, ургац хураалт 100 хувьтай явагдаж байна.

“Жимс, жимсгэнэ” хөтөлбөрийн хүрээнд сумын хэмжээнд жимс тариалагчид, тариалалтын төрлийг нэмэгдүүлэх зорилгоор “Жимсний мод” арга хэмжээг 14 хоногийн хугацаанд зохион байгууллаа. Уг арга хэмжээний хүрээнд торниун алим, бэсрэг алим, чавга, лийр, хар интоор, улаан интоор, хөх далан хальс, үхрийн нүд зэрэг нийт 8 төрлийн жимсний 147 ширхэг суулгацыг Улаанбаатар хот, Ховд, Дархан-Уул, Увс аймгийн мэргэжлийн жимсний мод, бут үржүүлэгчдээс авч 52 иргэнд захиалгын дагуу нийлүүлсэн байна. Мөн шинээр гадаа өвөлжүүлдэг парк сарнайн суулгац 7 ширхэгийг 4 иргэнд нийлүүлж тарих мод бутны төрөл тоог нэмэгдүүллээ.

Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд малчдын хадлан бэлтгэлийн явц 76,8 хувьтай явагдаж 7034 тн өвс бэлтгэхээс 6500 тн бэлтгээд байна. Бизнес хадлан 647 га талбайгаас 31506 боодол буюу 630 тн өвс бэлтгэн, 120 тн өвсийг өөр аймаг, суманд борлуулсан байна. Сумын аюулгүйн нөөцөд 100 тн өвс, үйлдвэрийн тэжээл 30 тн бэлтгэхээс 2790 боодол буюу 55.8 тн өвсийг татан авч эхлээд байна.

Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хэсгийн бүрэлдэхүүн хөдөөгийн малчдаар тойрч 69 малчин өрхийн 173 хүнд өвөлжилтийн бэлтгэл хангах, эр сувай малыг эдийн

засгийн эргэлтэд оруулах, сумын бэлчээрийн өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудал, мал бүртгэлийн журам, Генетик нөөцийн тухай хууль, Малын тоо толгойн татварын хууль, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Ноосны урамшууллын журам, Байгаль орчныг хамгаалах талаар зөвлөгөө мэдээлэл өгч гарын авлага тараалаа.

Энэ онд хээлтүүлэгт орвол зохих 18927 эм хонь, 14452 эм ямаа байна. Хээлтүүлэгчийн тохироогоор 379 хуц, 289 ухна шаардлагатай байгаагаас дутагдалтай 166 хуц, 127 ухна байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/272 тоот захирамжийн дагуу ээлжит цэргийн албаны татлага хуваарийн дагуу Сайхан суманд зохион байгуулагдлаа. Цэрэг татлагад 45 хүн хамрагдаж 8 иргэн цэргийн албанд явсан байна.

“Хоггүй цэвэрхэн сум болцгоо” аяны хүрээнд бүх нийтийн хог цэвэрлэгээг зохион байгуулж, төсвийн 5 байгууллага, аж ахуйн нэгжийн 70 гаруй ажилтан албан хаагч, 45 иргэд хамрагдаж 54 м3 хог цэвэрлэлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 63 дугаар зарлиг “Мод тарих үндэсний өдөр”, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Нэг тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд сумын төр төсвийн байгууллагууд, өрх иргэд мод тарьж ногоон байгууламжаа нэмэгдүүллээ. Сумын хэмжээнд нийт 16 төрлийн 2347 ширхэг модны суулгац таригдлаа. Эдгээрийн 30 хувийг нь 8 төрлийн жимсний суулгац, 70 хувийг нь 8 төрлийн гоёлын мод эзэлж байна.

“Дэлхийн Зөн Монгол” ОУБ-аас “Хашаандаа сайхан амьдаръя” төслийн хүрээнд төгсөлтийн аргачлал арга хэмжээнд хамрагдаж байгаа 20 өрх тус бүрт 50 ширхэг, нийт 5 төрлийн жимсний болон гоёлын модны 1000 ширхэг суулгац өгсөн байна.

Олон Улсын ахмадын баярыг тохиолдуулан сумын ЗДТГ, хөдөө аж ахуйн тасаг, ахмадын хороотой хамтран улс, аймаг, сумын аварга малчдын дэмжлэгтэйгээр “Аваргын хишиг” арга хэмжээг зохион байгуулж 11 ахмад настанд хундан цагаан хонь бэлэглэлээ. Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сумын хэмжээнд 46 аж ахуй нэгж байгууллагад 306 ахмад настныг харьяалуулсанаас одоогоор 27 аж ахуйн нэгж байгууллага 193 ахмад настанд хүндэтгэл үзүүлж гарын бэлэг гардуулсан байна.

Чанарыг эрхэмлэх жил” -ийн хүрээнд аймгаас зохион байгуулсан “Сэлэнгэ ургац 2021” үзэсгэлэн худалдаанд сумаас төлөөлөл болж 2 иргэн цагаан идээ, даршилсан ногоо, жимс, гурилан бүтээгдэхүүн, оёмол бүтээгдэхүүн зэрэг 5 нэрийн 17 төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 645.000 төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгө 60,0 сая төгрөг, сумын ОНХС-ийн хөрөнгө 10,0 сая нийт 70,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Шандын давааны зам засвар”-ын ажлыг “Нигүүлсэн зам” ХХК хийж гүйцэтгэлээ.

Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 8 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/295 тоот хамтарсан тушаал Коронавируст халдварын үед Ерөнхий боловсролын сургуулийн хичээл, цэцэрлэгийн үйл ажиллагаандаа мөрдөх түр журмын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Тайлант сард 22 тохиодолд тандалт хийж, Ковид-19 халдвараар өвчилсөн 5 хүүхдийн ойрын хавьтлыг сургууль, цэцэрлэгийн тандалтын багтай хамтран тогтоож тусгаарлалтад оруулаад байна.

“Дэлхийн Зөн Монгол” ОУБ-аас хүүхдийг цэвэр, эрүүл орчинд сурч хөгжих нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж ерөнхий боловсролын сургуульд гар ариутгах санитол болон гар ариутгах 4 төхөөрөмж, цэцэрлэгт Хүүхэд хамгааллын зурагт самбар, 4 ширхэг хог ангилах, ялгах хогийн савыг өглөө.

Сүхбаатар сум:

Иргэний нийгмийн байгууллагуудын хамтран зохион байгуулсан “Хамтарсан багийг чадавхжуулах” сургалтад 8 багийн Засаг дарга, нийгмийн ажилтнууд, сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс гэр бүл, хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр олон нийтийн нөлөөллийн ажлуудыг зохион байгуулж “Дэлхийн зөн Монгол” ОУБ-ын Сэлэнгэ нутгийн хөтөлбөр, “Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг зогсооё” төслийн багтай хамтран “Сэтгэцийн гэмтэлд суурилсан хохирогч-давантуулагчдад ээлтэй үйлчилгээ үзүүлэх аргачлал” сургалтад албан хаагчдаа тус тус хамрууллаа.

“2021 оны хоёрдугаар ээлжийн хугацаат цэргийн албаны татлага зохион байгуулах тухай” аймгийн Засаг даргын А/255, сумын Засаг даргын А/199 тоот захирамжийн дагуу уг ажлыг зохион байгуулж 18-25 насны 30 залуу цэргийн албанд татагдлаа.

Монгол улсад Зэвсэгт хүчин байгуулагдсаны 100 жил, Чөлөөлөх дайны ялалтын 76 жилийн ой, Монгол Улсад ахмадын байгууллага үүсч хөгжсөний 90 жилийн баярын хүрээнд Сүхбаатар сумын 7-р багийн иргэн, Сүхбаатарын одон, Байлдааны гавьяаны улаан тугийн одон, Алтан гадас одон, Шатрын спортын мастер, Хүндэт төмөр замчин өдгөө 95 нас сүүдэр зооглож буй ахмад дайчин Г.Дашхүү гуайд аймгийн цэргийн штаб болон Засаг даргын Тамгын газраас хүндэтгэл үзүүллээ.

Сүхбаатар суманд Европын холбооны дэмжлэгтэйгээр “Дэлхийн Зөн Монгол” ОУБ, “Хөөрхөн зүрх” ТББ-ын хамтран хэрэгжүүлж буй “Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг зогсооё” иргэний нийгмийн байгууллагуудыг чадавхжуулах төслийн хүрээнд ОУ-ын зочид төлөөлөгчдийг хүлээн авч уулзалт зохион байгууллаа. Тус уулзалтаар одоо хэрэгжиж буй төсөл хөтөлбөрөөс гадна байгаль орчин, боловсрол, эрүүл мэнд, оюутан солилцооны талаар цаашид хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа сумын удирдлагууд илэрхийлж харилцан санал солилцлоо.

Аймгийн Онцгой комиссын 2021 оны 6100 тоотын дагуу сумын Засаг даргын А/223 тоот захирамжаар тус сумын хэмжээнд ресторан, бар, саун, караоке, сүм, хийд, бүжгийн заал, спорт заал, цахим тогтоолмын газрын үйл ажиллагааг 10 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн нээлээ.

2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газарт тандалт судалгааны баг ажиллаж нийт 593 иргэдээс тандалт судалгаа авч Өрхийн эрүүл мэндийн төвтэй холбон зуучлах, эмийн багц тараах, тухайн халдвар авсан иргэний ойрын хавьтал болсон 1861 иргэнийг ПСР шинжилгээнд хамруулан ажиллалаа.

Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 63 дугаар зарлиг, “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 178 дугаар зарлиг, аймгийн Засаг даргын 2021 оны А/138 дугаар захирамж, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны 479 албан тоот албан бичгийн хүрээнд Сүхбаатар суманд “Бүх нийтээр мод тарих” өдрийг сумын Засаг даргын 2021 оны А/205 дугаар тоот захирамжаар 10 дугаар сарын 07-10 өдрийн хооронд зохион байгууллаа. Тус ажлын хүрээнд “Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, үзэсгэлэн худалдаанд Мод үржүүлэг, тарьц суулгацын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 3 аж ахуйн нэгж, 4 иргэн Хайлаас, Далайн хайрст, Голт бор, Шар хуайс, Хар интоор, Өрөл, Буйлс, Агч, Улаалзгана, Үхрийн нүд, Тэхийн шээг, Герман Бөөрөлзгөнө, Алим зэрэг 14 төрлийн суулгацаар оролцлоо. Мөн тарьц

суулгацаас гадна даршилсан ногоо, зөгийн бал, тасалгааны цэцэг зэрэг олон төрлийн зүйлийг худалдан борлуулсан.

Сумын хэмжээнд ургац хураалт төмс 72 га-аас 684 тн, хүнсний ногоо 48,5 га-аас 518 тн тус тус хураан авч ургац хураалт 100 хувь явагдаж дууссан. Намрын ургац хураалтын ажилтай холбоотойгоор суманд үйл ажиллагаа явуулдаг 6 ШТС-аас түлшний нөөцийн судалгааг цаг тухайд нь авч холбогдох байгууллагад өгч ажиллаж байна.

“Сэлэнгэ ургац 2021” үзэсгэлэн худалдаанд 6 иргэн төмс, хүнсний ногоо болон модны суулгацтай оролцож 2.320.000 төгрөгийн худалдан борлуулалт хийлээ.

Австри Улсын Засгийн газрын хөрөнгөөр “Дэд бүтэц төслийн хүрээнд” 800 ширхэг гэрэлтүүлэг хийгдэж байгаатай холбогдуулан Бор гүвээний 5-р баг, Буур хээрийн 8-р баг, Хонгор морьтын 1-р багуудад хийгдэж байгаа гэрэлтүүлгийн ажилд хяналт тавьж зайлшгүй зам сэтлэх ажлуудад хяналтыг тавьж замыг сэтлүүлэх ажлыг “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-аар гүйцэтгүүлж байна. Мөн гэрэлтүүлэг хийгдэж байгаатай холбогдуулан нийтийн эзэмшлийн зам дагуу овоолсон шороог тэгшлэх ажилд нийтийг хамарсан ажлын төсөл бичиж баг бүрээс 6 иргэнийг авч ажилуулсан.

Тус суманд 240 гэрэлтүүлгийн шонг зөөх ажлыг “Гандирын тал” ХХК-нь хийж гүйцэтгэхээр 8 багуудад гэрлийг шонг хувиарлах ажлыг хийлээ Үүнд: 1-р багт 47, 2-р багт 15, 3-р багт 20, 4-р багт 41, 5-р багт 35, 6-р багт 10, 7-р багт 8, 8-р багт 45, 1-р сургуулийн гадна талбайд 8, 4-р сургуулийн гадна талбайд 3, Цэцэрлэгт хүрээлэнд 8 ширхэгийг тус тус суурилуулах ажлыг зохион байгуулан ажиллалаа.

Түшиг сум:

Үр тариа, төмс, хүнсний ногооны ургац хураалт төмс 17 га-аас 194 тн, хүнсний ногоо 20.7 га-аас 151,6 тн, Үр тариа 9415 га-д тариалалт хийснээс 4861 га тайбайгаас 8980 тн хураасан. Үүнээс улаанбуудай 4381 га-аас 8072 тн, Овьёос 380 га-аас 608 тн, Рапс 582 га-аас 937.6 тн хураалт хийгээд байна. 10 дугаар сарын байдлаар нэгж га-с 18 цн үр тариа хурааж, ургац хураалт 59 хувьтай байна.

10 дугаар сард сумын хэмжээнд 58 тохиолдол, өссөн дүнгээр нийт 280 эерэг тохиолдол бүртгэгдээд байна. Аймгийн Ковидын халдварыг эмчлэх тасагт 4, гэрээр тусгаарлан эмчилсэн 39, гэрээр тусгаарлан эмчлэгдэж байгаа 15 иргэн байна.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хичээлийн жилд танхимын сургалтаар өдрийн 3 бүлэгт 67 хүүхэд, зайн сургалтаар 3 бүлэгт 78 хүүхэд, хувилбарт сургалтаар 5 хүүхэд ба нийт 150 хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх зорилготой сургалтын үйл ажиллагааг цахим, танхим гэсэн хосолсон хэлбэрээр явуулж ажиллаж байна. 4-5 насны танхимын сургалтад хамрагдаж чадахгүй байгаа хүүхдүүдийг цахим сургалтаар, 2-3 насны хүүхдүүд болон хамруулж 7 хоног тутамд 1 удаа МЕЕТ программ ашиглан цахим уулзалтыг хийж зайн сургалтыг явуулж байна. 3 бүлэгт 4-5 настай 65 хүүхэд танхимаар, цахимаар 2-3 настай 78 хүүхэд хичээллэж байна.

Ерөнхий боловсролын сургуульд 15 бүлгийн 357 сурагч 12 танхимд суралцаж, дотуур байранд 59 сурагч хүлээн аваад байна.

13 сурагч ковид-19 халдвараар өвчилж одоогоор 5 сурагч тусгаарлагдан эмчлэгдэж байна. Мөн Дотуур байранд өвчлөл бүртгэгдэж 4 хоног гэрийн тусгаарлалтад шилжүүлж ажилласан.

Томуугийн вакциныг 220 сурагч хамрагдахаас 199 хамрагдсан.

“Шинэбадрах” ХХК Хар горхид 40 га ойжуулалт нарс модны суулгацаар, УБТЗ-ын харъяа мод боловсруулах үйлдвэр Баруун хужирын даваанд 60 га-д шинэс модны тарьцаар, “Мойлт нуга” ХХК нөхөн тарилтыг 10 га-д, Рашаантын аманд 15 га-д Шинэс

модны тарьцаар ойжуулалт хийж гүйцэтгэснийг Сэлэнгэ бүсийн сум дундын ойн ангитай хамтран хүлээн авсан.

Улаан овоогийн нүүрсний уурхайд ашиглалт явуулж буй “Техно перспектив” ХХК-ий үйл ажиллагаанд Экологийн цагдаагийн алба, аймгийн Мэргэжлийн хяналтын газартай хамтран хяналт шалгалт явуулж уурхай дээр байх бичиг баримтын бүрдэл хангалтгүй гэсэн шалтгаанаар үйл ажиллагааг түр зогсоож, хугацаатай албан шаардлага өгөөд байна.

“Тэр бум мод” үндэсний хөдөлгөөнийг сумандаа өрнүүлж 2 байгууллага, 18 айл өрхийн 38 иргэн хамрагдаж Нарс 48, Гацуур 12, гоёлын болон жимсний мод 25 ширхэгийг тус тус тарьсан.

Сумын төвлөрсөн хогийн цэгт үүсээд байсан 2,8 га талбайн 7800 м³ хогийг Шар нарст ХХК-тай байгуулсан гэрээний дагуу тухайн аж ахуйн нэгжийн техникээр түрж, булаах ажлыг хийж гүйцэтгэсэн.

2021 оны ээлжит цэрэг татлагын ажлыг зохион байгуулж, 17 цэргийн насны залуучууд хамрагдаж 5 иргэн цэрэгт тэнцэж цэргийн албанд татагдсан.

Золбин нохой устгалын ажлыг 2 багийн нутаг дэвсгэрт зохион байгуулж 739,200 төгрөгийн зардал гаргаж 32 нохой устгах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Ковид-19 цар тахалтай тэмцэх ажилд Засаг даргын нөөц хөрөнгөөс 405,600 төгрөгийн зардал гарсан.

Хушаат сум:

10 дугаар сард нийт 179 иргэн ковидийн шинжилгээ өгснөөс түргэвчилсэн шинжилгээ 179 иргэнээс авч 24 иргэний ковидын халдвар батлагдан 11 иргэнийг аймаг, бусад сумдын эрүүл мэндийн байгууллагад эмчлүүлэхээр шилжүүлж 13 иргэн сумын Эрүүл мэндийн төвийн хяналтад гэрээр эмчилгээ хийгдсэн.

Цэцэрлэгийн хичээл үйл ажиллагааг зөвхөн 4-5 настай хүүхдүүдийг хүлээн авахаар шийдвэрлэж 2 бүлгийн хичээл үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Бэлтгэл бүлэг нийт 28 хүүхдээс танхимаар 14, цахимаар 14, ахлах бүлэг нийт 25 хүүхдээс 10 хүүхэд танхимаар 10, цахимаар 15 тус тус байна.

Ерөнхий боловсролын сургуулиас тус сард багш, ажилчдынхаа дунд “Сурган хүмүүжүүлэх хурал” зохион байгуулж багшийн ёс зүйн тангараг бүх багш, ажилчид өргүүллээ.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 08 дугаар тогтоолоор батлагдсан 2021 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүдэр сум:

Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд “Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлж “Дархан төмөрлөг” ХХК, “Хүдэр тохижилт” ОНӨААҮТГ хамтран Хүдэр сумын төвлөрсөн хогийн цэгийн 15 га талбайн ахуйн хог хаягдал болон шатаж байгаа үртэсийг бүрэн цэвэрлэж хүлээлгэн өглөө.

Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар:

1. Эрүүл мэндийн төвд 5.900.000 төгрөгийн санхүүжилтээр сургалтын танхим байгуулах болон 8.000.000 төгрөгөөр гал тогооны тоног төхөөрөмжийг шинэжлэх ажил хийгдсэн.

2. ЭХАС-ын фургон машины засвар 2.750.000 төгрөгөөр засварлах

3. ЕБС-ийн газарзүйн болон биеийн тамирын танхимд 17.475.000 төгрөгийн тоног төхөөрөмж сургалтын хэрэглэгдэхүүнийг авч тохижуулах

4. Цагдаагийн байрны гадна пасад 8.653.000 төгрөгөөр засварлах

5. Замын сангийн 32.500.000 төгрөгийн хөрөнгөөр гудамж, хорооллын 7 км замыг засварлах ажлуудыг тус тус хийж гүйцэтгэлээ.

Дэлхийн зөнгийн хөрөнгө оруулалтаар: ЕБС-ийн дотуур байранд 245.000.000 төгрөгөөр ариун цэврийн байгууламж болон шинэ суурьшлын бүс болох Баянцагаан багийн Дэнж хороололд гүний худаг барих ажил 90 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

Малын тоо толгойн албан татварын тухай хууль 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс эхлэн хэрэгжиж эхэлсэн. Сумын хэмжээнд малын тоо толгойн албан татвар төлөгчөөр нийт 418 татвар төлөгч бүртгэгдсэн байна, үүнээс малчид 136 иргэн, мал бүхий иргэд 282 . Өмнөх оны жилийн эцсийн тооллогоор адуу 3561, Үхэр 9662, Хонь 11275, Ямаа 11394 нийт 35892 тоо толгой мал тооллогдсон байна. Сумын төсөвт энэ сард 24 иргэнээс 2987,1 мянган төгрөгийг татвар хураан авч төсөвт төвлөрүүлсэн байна.

Сумын хэмжээнд ургац хураалт 7025 га-гаас хураан авахаас 5330-га-гаас хураан авч ургац хураалт 75.8 хувьтай байна. Үр тариа га-гаас авах ургацын хэмжээний дундаж 13 цн авсан байна. 10 дугаар сарын байдлаар 7195 тн буудай хураан авч гурилын үйлдвэрт 120 тн, Хөдөө аж ахуйг дэмжих санд 720 тн буудай тус тус тээвэрлэгдсэн байна.

Аж ахуйн нэгж, иргэд 68 га-д төмс тариалж 59-га-гаас 470 тн төмс, хүнсний ногоо 44 га-д тариалж 450 тн хураан авсан байна.

Малчид мал бүхий иргэд өвөлжилтийн бэлтгэл ханган 450 тн өвс, 30 тн тэжээлийн будаа, 5 тн хужир, түлээ модоо бэлтгээд байна. Бизнесийн хадлан бэлтгэсэн иргэд 230 тн боодлын өвс бэлтгэн зах зээлд борлуулахад бэлэн болсон байна.

10 дугаар сард малын эрүүл мэндийн гэрчилгээ олгох цахим системд 42 удаагийн гэрчилгээг цахимаар шивсэн. Үүнд адуу 11 толгой, үхэр 35, хонь 21, ямаа 27, үхрийн мах 3741, гахайн мах 120 кг, хонины мах 95 кг, аарц 8 кг тус бүр эрүүл мэндийн гэрчилгээ олгож хяналт тавиллаа.

“Бруцеллёзын тандалт-2021” судалгаанд 79 өрхийн бух 80, хуц 40, ухна 50 толгойг хамруулсан.

Сумын Засаг даргын “Ойд үйл ажиллагааг зогсоох тухай” захирамжийн хүрээнд хяналт шалгалтыг 1 удаа хийсэн. Хяналт шалгалтын явцад Ойгоос мод бэлтгэх журам зөрчсөн 1 иргэнд Зөрчлийн тухай хуулийн 7.9.10 дахь заалтаар хялбаршуулсан журмаар арга хэмжээ авч ажилласан.

“Нөхөн сэргээлт-2024” арга хэмжээний хүрээнд тус суманд төмрийн хүдэр олборлох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Дархан төмөрлөг” ХХК нь Уулын ажлын төлөвлөгөөний дагуу дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн ажлыг “Хүдэр эв энерги” ХХК-тай хамтран Баянцагаан 2-р багийн нутаг дэвсгэр Цагаан зүрийн гол дагуу техникийн нөхөн сэргээлтийг 10 га албайд хийж гүйцэтгэн ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлиг, 2013 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 178 дугаар зарлиг, сумын Засаг даргын захирамжийн дагуу Бүх нийтээр мод өдрийг 10-р сарын 15-ны өдөр зохион байгуулан аж ахуйн нэгж байгууллагад нийтийн эзэмшлийн талбайд тарьсан мод бутанд арчилгаа хамгаалалтыг хийж гүйцэтгэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, 15 өрхийг 4 төрлийн 200 ширхэг жимсний мод бутар хангаж ажиллалаа.

/Ковид-19/ өвчнөөс сэргийлэх пайзер вакцины 1 тунг 6 хүн, 2 тунг 12 хүн, 3 тунг 642 хүн, вероциль 3 тунг 1 хүнд тус тус хийгдсэн. Томуугийн вакциныг 451 хүнд хийв. Хөдөөгийн малчин өрхийн 65-аас дээш насны 13 ахмадуудад дархлаажуулалтын багц өгсөн. Мөн малчин өрхийн 96 иргэнд пайзер вакцины 3 тунг хийсэн.

Коронавирус илрүүлэх түргэвчилсэн шинжилгээг 268 иргэнд хийж сэжигтэй илэрсэн 39 иргэний PCR сорьцийг аймгийн вируслогийн лабораторид илгээж онош баталгаажуулан батлагдсан тохиолдлыг үнэлэн аймгийн ковидын тасагт 10, Дархан 2, Ерөөгийн ковидын тасагт 4 иргэнийг хүргэн, 24 хүүхэд, 114 иргэнийг гэрийн тусгаарлалтад эмийн багц тараан хяналт, үнэлгээ хийн зөвлөгөө өгөн ажиллаж байна.

Сургуулийн өмнөх боловсролд 3-5 насны 171 хүүхэд хамрагдсанаас танхимаар 71 хүүхэд, зайгаар 100 хүүхэд хамрагдаж сургалт үйлчилгээг авч байна. Цэцэрлэгт танхимаар 4-5 насны 71 хүүхэд, нэг өдөр ирэх хүүхдийн ор хоногийн төлөвлөгөө 10 сарын 1-20 хүртэл 994 ор хоног ажиллахаас 547 ор хоног ажиллаж 55 хувьтай ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны “Бүх нийтийн ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг эрчимжүүлэх тухай” А/15 тоот захирамжийн дагуу 915 м² талбайд ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж ажиллалаа.

Ерөнхий боловсролын сургуульд нийт 630 сурагчид сурч байгаа бөгөөд бага ангид 330 сурагчид танхимын хичээл хамрагдал 82,1 хувьтай, ахлах ангийн сурагчид 300 танхимын хичээл хамрагдал 87 хувьтай байна. /Ковид-19/ халдвараар 4 сурагч өвчилсөн.

6-11 насны 337 хүүхэд томуугийн вакцинд хамрагдахаас 273 хүүхэд хамрагдаж, 18 хүн томуугийн вакцин хийлгэсэн.

Цагааннуур сум:

Коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд сумын Онцгой комисс, шуурхай штабын бие бүрэлдэхүүн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт ажиллаж Засгийн газар, улс, аймгийн онцгой комиссоос гаргасан албан даалгавар, тогтоол, шийдвэр, чиглэлийн дагуу ажиллаж байна.

Сумын хэмжээнд 239 иргэн коронавируст халдварт өвчнөөр өвчилсөн байна. Үүнээс 0-17 насны 28, 18-аас дээш насны 211 иргэн байна. Эдгэрсэн 200 иргэн байна.

Эрүүл мэндийн төвийн ковидийн тасагт 10 дугаар сарын байдлаар 28 батлагдсан тохиолдол, 1 ойрын хавьтал хэвтэн эмчлүүлж байна. Үүнээс 0-17 насны 9, 18-аас дээш насны 28 иргэн байна.

2021 оны хоёрдугаар ээлжийн хугацаат цэргийн албаны татлагын эрүүл мэндийн үзлэгт цэргийн насны 45 залуучуудыг хамруулж, 11 залуус эрүүл мэндийн үзлэгээр тэнцсэн.

Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, сумын Засаг даргын Тамгын газартай хамтран “Газрын харилцааны цахим шилжилт” сургалт, сурталчилгааны нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж 3 байгууллагын 65 албан хаагч оролцсон.

Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Хуурч 2 дугаар багт хүүхдийн тоглоомын талбай барих ажил, аймгийн болон сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар сумын төв доторх хатуу хучилттай замын үргэлжлэл 330 м замын тавих ажлууд эхэлсэн.

2021-2022 онд сумын хэмжээнд бэлтгэх мал, махны судалгааг малчин мал бүхий иргэдээр гарган нэгтгэж, нийт 35 малчин 8 адуу, 45 үхэр, 880 хонь, 595 ямаа бэлтгэхээр судалгаанд хамрагдав.

Малчин, мал бүхий иргэд, аж ахуйн нэгжүүд 10 дугаар сарын байдлаар нийт хадлан 14300 тн, ногоон тэжээл 1400 тн, дарш, хүнсний ногооны хаягдал 920 тн, хужир шүү 950 тн бэлтгэж, сумын аюулгүйн нөөцөд 60 тн өвс нөөцөлсөн байна.

Сумын хэмжээнд нийт 486 өвөлжөө байгаагаас тариалангийн талбайгаас 500 м дотогш өвөлжөө 34 байна.

10 дугаар сарын байдлаар халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын гүйцэтгэл 99 хувь, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх цахим системийн гүйцэтгэл 83 хувь, хашаа хорооны ариутгал халдваргүйжүүлэлт 30 хувьтай байна. Мал эмнэлгийн цахим гэрчилгээ 229 бичигдсэн.

Нам даваанаас цааш Зэлтэрийн 10 нарст хүртэл ойн ангитай хамтран замын трамст багтсан моднуудыг тоолж, тэмдэглэлээ.

“Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөн”-д нэгдэн сумын Засаг даргын Тамгын газрын хамт олон “Атар-50” цогцолборт хүрээлэнд 30 ширхэг, хатуу хучилттай зам дагуу 45 ширхэг нарс тарьсан.

Сумын Засаг даргын 2021 оны А/105 тоот “Бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах тухай” захирамжийн хүрээнд төр, төсвийн байгууллага, худалдаа үйлчилгээ эрхэлдэг иргэн, аж ахуй нэгж байгууллагууд нийтийн эзэмшлийн зам, талбайн 18 тн хог хаягдлыг цэвэрлэж хогийн нэгдсэн цэгт буулгасан.

Шаамар сум:

Монгол Улсын Засгийн газрын 105 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны “Түр журам батлах тухай” 46 дугаар тушаал, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 тоот хамтарсан тушаалы гүйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллалаа.

Аймгийн Засаг даргын 2021 оны “Бүх нийтийн ариутгал халдваргүйжүүлэлтийн эрчимжүүлэх” А/15 тоот захирамж ажлын хүрээнд Дулаанхаан тосгоны төр, төсвийн 32, худалдаа үйлчилгээний 18 байгууллагын нийт 21586,2 м² талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийж ажилласан.

10 дугаар сард Коронавирусын нийт 27 тохиолдол бүртгэгдсэн. Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх талаар мэдээ, мэдээллийг Шаамар ЗДТГ, Шаамарынхан, Шаамар ЕБС, Бид Шаамарынхан, Шаамар Эрүүл мэндийн төв, Шаамар Соёлын төв, Шаамар зар, Шаамар сум, Шаамар МСҮТ, Шаамар 1-р цэцэрлэг, Шаамар 2-р цэцэрлэг, Дулаанхаан сайхан нутаг зэрэг цахим хаягуудад байршуулан ажиллаж байна.

Сумын Засаг даргын 2021 оны “2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” А/115 тоот захирамжийн дагуу ургацын урьдчилсан тогтоолт явуулах, ургац хураалтыг чанартай зохион байгуулахад хяналт тавих ажлын хэсэг, төр төсөв, албан байгууллагын өвөлжилтийн бэлтгэл ажилд хяналт тавих ажлын хэсэг, мал аж ахуйн урьдчилан сэргийлэх, иргэдээр хадлан тэжээл бэлтгүүлэх, хяналт тавьж ажиллаж байна.

Сумын хэмжээнд нийт 8845 га газраас Дэлгэрхаан 1-р багт 125 иргэнд 1715 га талбай, Охиндий 2-р багт 67 иргэнд 585 га талбай, Дулаанхаан 3-р багт 175 иргэнд 780 га талбай Сүхбаатар сумын 15 иргэнд 205 га талбай, Сэлэнгэ аймгийн ОБЕГ-т 20 га талбай газар хувиарласан байна. Нийт 3305 га талбай газарт гэрээ хийснээс 16425 тн хадланг бэлтгэсэн байна үүнээс сумын нөөцөнд 2600 тн өвс байна. Тус сумын Охиндий 2-р багт 1200 га талбай үерт автсан байна.

Хүнсний ногоо нийт 2904,6 тн, төмс 1128 тн, улаан буудай 1217 тн хурааж авсан байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны “Хугацаат цэргийн албаны ээлжит татлага зохион байгуулах” А/272 тоот захирамжийн хүрээнд сумын Засаг даргын захирамжийг гарган холбогдох мэргэжилтэн, албан тушаалтнуудыг томилгоожуулан сумын хэмжээнд

зарлан дуудах мэдээг нийт 179 хүнд тараагдахаас эзэндээ хүрсэн 133, эзэндээ хүрээгүй 19, шилжсэн 3, хаягандаа байхгүй 9, гадаад явсан 8, эмнэлэгт хэвтсэн 3 мэдээ тараагдсан байна. Сумын хэмжээнд нийт 9 залуучууд цэрэгт татагдсан байна.

Тарьц суулгац модны үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, үзэсгэлэн худалдаанд нийт 7 иргэн аж ахуй нэгж бүртгүүлснээс 5 аж ахуй нэгж байгууллага оролцсон. Б.Отгонбаяр захиралтай “Ой баясах” ХХК-ий зүгээс Шаамар суманд 1000 ширхэг хайлаасны тарьц суулгацыг хандивлалаа.

“Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх, иргэн бүр, өрх бүр мод тарьж ургуулах тухай уриалга, зөвлөмж бүхий зурагт хуудас, шторк зэргийг бэлтгэж сумын зарын нэгдсэн групп болох “Шаамар сум” хуудсанд байршуулж сурталчилж ажилласан. Нийт 11 төрлийн 298 мод тарьж суулгасан.

“Сэлэнгэ ургац 2021” үзэсгэлэн худалдаанд төмс, хүнсний ногоо, зөгийн аж ахуй эрхлэгч нийт 10 иргэн оролцож 2 өдөрт нийт 8.290.000 төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны “Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг зохион байгуулах тухай” А/236 тоот захирамжийн хүрээнд дархлаажуулалтын ажил 85 хувьтай явагдаж байна. Угаалгад үхэр 600, хонь 7551, ямаа 7808, туулгалтад адуу 2152, үхэр 7946, хонь, ямаа 15359, гахай 120, нохой 280, боловсруулалтад үхэр 7946, хонь, ямаа 15359, гахай 120 толгой мал, амьтанг тус тус тарилгад хамруулсан. Сумын Засаг даргын 2021 оны А/131 тоот захирамжийн хүрээнд 20 нохойг Шаамар сумын төвлөрсөн хогийн цэгт хаяж овоолж шатааж устгаж 25 кг хлорын шохойгоор халваргүйтгэлийг хийж гүйцэтгэлээ.

Хүчирхийллийн эсрэг хамтарсан баг, сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хамтран гэр бүлийн хүчирхийллийг эрт үед илрүүлэх, хүүхдийг гэмт хэрэг, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, эцэг эх, асран хамгаалагч, иргэд, гэр бүлийн гишүүдийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, төр иргэний хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөс 2022 оны 01 сарын 21-ныг хүртэлх хугацаанд “Хүчирхийлэлгүй орон нутаг болцгооё” аяныг эхлүүлсэн.

“Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа” аймгийн хөтөлбөрийн хүрээнд суманд баригдсан 25 айлын орон сууцыг аймаг, орон нутгийн Засаг даргын санаачлагаар, аймгийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад оруулах, төрийн албан хаагчдыг хүүгүй, урьдчилгаагүй нөхцөлөөр орон сууцанд хамруулах талаар танилцуулах, хамрагдах албан хаагчдын саналыг авах асуудлаар сумын Засаг даргын Тамгын газрын даргатай хамтран Ерөнхий боловсролын сургууль, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, 1,2 дугаар цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвийн албан хаагчидтай уулзаж санал солилцож байранд орох хүсэлтэй 31 албан хаагчийн судалгааг холбогдох байгууллагад хүргүүлсэн.

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН

ГАЗРЫН ДАРГА

Ө.СУВДАА

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИДЛАГЫН

ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Д.АЛТАНТУЯА